

СЭДЭВЧИЛСЭН ХУРААНГУЙ



planet**GOLD**
Mongolia

Бичил уурхай дахь албан ёсны санхүүжилтийг нэмэгдүүлэх арга замууд



Агуулга

1. Танилцуулга	3
2. Санхүүжилтийн талаарх ерөнхий ойлголт	5
2.1 Санхүүжилтийн хэлбэрүүд	5
2.2 Нөхцөл боломж муутай салбарын санхүүжилтийн бүтэц	6
2.3 Албан ёсны хөрөнгө оруулагчдын ангилал	7
3. Алтны бичил уурхайн санхүүжилтийн дэлхий нийтийн туршлага	8
3.1 Албан бус санхүүжилт	8
3.2 Бичил санхүүжилт	8
3.3 Засгийн газраас хэрэгжүүлсэн санхүүжилтийн багцууд	9
3.4 Холимог санхүүжилт	11
3.5 Хөрөнгө оруулагчид	11
3.6 Уул уурхайн салбарын бизнесийн зохион байгуулалт	12
4. Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд албан ёсоор санхүүжилт авахад тулгардаг саад бэрхшээл	13
4.1 Санхүүжилт авахад тулгардаг саад бэрхшээл	13
4.2 Санхүүжилт олгоход тулгардаг саад бэрхшээл	14
5. Алтны бичил уурхайн албан ёсны санхүүжилтийг нэмэгдүүлэх нь	16
5.1 Алтны бичил уурхайн салбар болон санхүүжилтийн талбар	16
5.2 Бодлогын таатай орчин бүрдүүлэх	17
5.3 Бичил уурхайчдын шаардлагад санхүүжилтийн эх үүсвэрийг нийцүүлэх нь	18
5.4 Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд тохирсон санхүүжилтийн механизм бүрдүүлэх	23
5.5 Алтны бичил уурхайн салбарт хувийн хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах	24
5.6 Бичил уурхайчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх	26
5.7 Алтны бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор салбарын бусад оролцогчдыг чадавхжуулах	29
5.8 Үр дүнг баримтжуулах	30
5.9 Санхүүжүүлэлт татахад тулгардаг саад бэрхшээлийг даван туулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний хураангуй	30
6. Алтны бичил уурхай нь эдийн засгийн үр өгөөжтэй салбар болж хөгжих боломжтой	32
7. Дүгнэлт	33
Хавсралт 1 – Хөрөнгө оруулалтын холбоо	34
Хавсралт 2 – Алтны бичил уурхайн санхүүжилтийн асуудлыг хүлээн зөвшөөрөх муруй	35
Хавсралт 3 – Сэдэвчилсэн хураангуйн тухай	36

1. Танилцуулга

Алтны бичил уурхай нь гар аргаар алт олборлогчид, тэдний гэр бүлийнхэн, хүдэр боловсруулах түвшинд үйл ажиллагаа эрхлэгчид гэх мэт дэлхийн сая сая хүний амьжиргааны чухал эх үүсвэр болж байна. Энэхүү үйл ажиллагаа нь ихэвчлэн албан бус байдаг хэдий ч хөгжиж байгаа улс орнуудын эдийн засгийн боломжоор дутмаг хөдөө, орон нутгийн орлого багатай олон иргэдийн хувьд орлогын гол эх үүсвэр нь болдог. Салбарын хэмжээнд дэлхийн алтны зах зээлийн 20 орчим хувийг бүрдүүлж, жилдээ ойролцоогоор 35 тэрбум ам.долларын үйлдвэрлэл явуулдаг байна.

Алтны бичил уурхай дахь хариуцлагагүй үйл ажиллагаа, мөнгөн усны хэрэглээ нь хүний эрүүл мэнд, нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэгч хүчин зүйл болдог. Харин байгаль орчинд нөлөө багатай, хариуцлагатай бичил уурхай нь амьжиргаа, орлогын эх үүсвэрийг бий болгож улмаар орон нутгийн эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх боломжтой байдаг. Дэлхийн хэмжээнд 100 гаруй сая хүн шууд болон шууд бусаар алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас амьжиргааны эх үүсвэрээ залгуулж байгаа бөгөөд салбарын хувьд улам өсч, өргөжсөөр байна. Бичил уурхай бүхий улс орнуудад алтны бичил уурхайн хариуцлагатай үйл ажиллагааг эдийн засгийн хурдасгагч хүч болгох, сөрөг нөлөөнөөс зайлсхийх, хууль эрх зүйн таатай орчны хүрээнд илүү цэвэр, үр ашигтай технологи нэвтрүүлэх, байгаль орчны хариуцлагыг хэрэгжүүлэх зэрэгт санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байна. Өнгөрсөн хугацаанд алтны бичил уурхайн салбарт бодлогын болон технологийн чиглэлээр зарим ахиц дэвшил гарсан боловч албан ёсны санхүүжилт авахад саад тотгор учирсаар байгаа билээ.

Алтны бичил уурхайн албан бус байдал, өндөр эрсдэлтэй салбар гэж үздэг олон нийтийн хандлагаас шалтгаалж албан ёсны санхүүжилт авах боломж хязгаарлагдмал байсан. Энэ үйл ажиллагааг голдуу орон нутгийн бичил уурхайчдын бүлэг, гэр бүлийн гишүүд, олборлосон алтаа борлуулах нөхцөлтэйгээр албан бусаар зээлдүүлсэн алтны болон мөнгөн ус худалдаалагчид санхүүжүүлдэг байна. Ийм албан бус санхүүжилт нь ихэнхдээ хямд төсөр технологи, тоног төхөөрөмж авахад л хүрэлцдэг. Энэ нь үр ашиг багатайгаас гадна хүний эрүүл мэнд, байгаль орчинд илүү их сөрөг нөлөө үзүүлдэг байна. Алтны бичил уурхайд илүү үр ашигтай, дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд ийм хөрөнгө оруулалтыг хувь хүн албан бусаар хийх боломжгүй, эсвэл хүсэлгүй байдаг.



Гэрэл зургийг Хуан Мануель Чаварриа



албан бус санхүүжилт нь бичил уурхайчдаас мөнгөн ус хэрэглэхгүй байх гэх мэт байгаль орчны, нийгмийн, засаглалын хариуцлагатай байдлыг тэр болгон шаарддаггүй байна.

Бичил уурхайчдын хувьд эдийн засгийн ямар нэгэн хөшүүрэггүйгээр байгаль орчин, нийгмийн болон засаглалын талаарх хандлага, практик үйл ажиллагаагаа өөрчлөхөд хүндрэлтэй байх талтай. Цаашилбал, тогтвортой үйл ажиллагааны үндэс суурь болсон ашигт малтмалын байгуул, ашиглалт, баяжуулалт болон нөхөн сэргээлтийг үр дүнтэй хийхэд шаардлагатай нэмэлт үйлчилгээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэх зардал өндөр байдаг учраас бичил уурхайчид тэр болгон авч ашиглах боломжгүй байдаг. Зарим тохиолдолд албан бус санхүүжилт авснаар бичил уурхайчид олборлосон алтныхаа ихэнх хэсгийг зээлдүүлэгчид өгөх ашиггүй нөхцөлтэй гэрээ хэлцэл хийж өрийн сүлжээний золиос болох эсвэл хууль бус мөнгөний урсгалд татагдан орох нөхцөл үүсдэг.

Бичил уурхайн салбарын тухайд үйл ажиллагаа нь албан бус байх, албан ёсны санхүүжилт авах боломжгүй байх зэрэг нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны хариуцлагагүй, өдөр хоног аргацаасан, тогтворгүй үйл ажиллагаа явуулах үндэс болж байна. Цөөн хэдэн бичил уурхайн байгууллага донор байгууллагын болон буцалтгүй тусламжийн чиглэлээр албан ёсны санхүүжилт авдаг байна. Алт нь өөрөө үнэ цэнэтэй ашигт малтмал, түүнчлэн хариуцлагатай, үр дүнтэй бичил уурхайн үйл ажиллагаанаас үр ашиг гарах боломж их байдаг боловч бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдаас энэ салбарт санхүүжилт хийсэн тохиолдол цөөн байдаг.

Хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг богино хугацаанд дэмжихэд буцалтгүй тусламжийн болон донор байгууллагын хөрөнгө оруулалт чухал үүрэг гүйцэтгэх боловч урт хугацаанд хариуцлагатай, тогтвортой, эдийн засгийн чадвартай бичил уурхайн салбарыг хөгжүүлэхэд албан ёсны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилт чухал ач холбогдолтой юм.

Харамсалтай нь албан ёсны санхүүжилт татахад алтны бичил уурхайн үйл ажиллагааны талаарх олон нийтийн сөрөг хандлага, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө, засаглалтай холбоотой эрсдэл, практик үйл ажиллагаа болон зах зээлийн асуудалтай холбоотой саад тотгор учирсаар байна. Иймээс алтны бичил уурхайн салбарт албан ёсны санхүүжилт татахад эдгээр асуудал, саад тотгорыг арилгаж, нөхцөл байдлыг сайжруулах шаардлагатай юм.

Энэхүү баримт бичигт алтны бичил уурхайн салбарт санхүүжилтийн болон бусад үйлчилгээг хүргэх явцад хуримтлуулсан туршлагыг дүгнэхийн зэрэгцээ албан ёсны санхүүжилт, хөрөнгө оруулалт хийхэд тулгарч байгаа саад тотгорыг нягтлан шинжилсэн. Төгсгөлд нь алтны бичил уурхайн салбарт хийх албан ёсны санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд аливаа улсын төр засаг, донор байгууллагууд болон бусад хамтрагч талууд хэрхэн ажиллах, юу хийх шаардлагатайг зөвлөмж болголоо.

2. Санхүүжилтийн талаарх ерөнхий ойлголт


Албан ёсны санхүүжилт, хөрөнгө оруулалт татахын тулд эхлээд санхүүжилтийн гол хэлбэрүүд, ялангуяа, санхүүжилт авах боломж багатай салбарт хөрөнгө оруулалт хийх үйл явцын бүтэц болон албан ёсны санхүүжилтийн түгээмэл эх үүсвэрийн талаар судалж мэдлэгтэй болох нь чухал ач холбогдолтой.

2.1 Санхүүжилтийн хэлбэрүүд

Аливаа санхүүжилтийг зээл болон хөрөнгө/капитал оруулах гэсэн үндсэн хоёр хэлбэрээр хийдэг. **Зээл** нь зээлдүүлэгч хэн нэгэн этгээдэд хүүтэй мөнгө зээлдүүлэхийг хэлдэг бөгөөд хүүг тусгайлан тохирсон хуваарийн дагуу цаг тухайд нь төлдөг бол үндсэн зээлийн хөрөнгийг мөн тохиролцооны үндсэн дээр бага багаар нь цувуулж төлөх, эсвэл зээл авсан хугацааны эцэст бүтнээр нь төлөх хэлбэрээр эргүүлэн төлж барагдуулдаг. **Хөрөнгө оруулах** гэдэг нь хөрөнгө оруулагч тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлж дэмжсэнээр тухайн бизнесийг бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн эзэмшихийг хэлнэ. Хөрөнгө оруулагч тухайн байгууллагын удирдлагын бүрэлдэхүүнд орж шийдвэр гаргах үйл явцад оролцох, нөлөөлөх боломжтой байдаг. Санхүүжилтэд тулгарч болзошгүй эрсдэлийг сааруулах зорилгоор зарим тохиолдолд зээлийн болон хөрөнгө оруулах хэлбэрийн аль алийг нь ашиглаж болно. Ингэж хийсэн санхүүжилтийг **мезанин буюу холимог санхүүжилт** гэж нэрлэдэг. Жишээлбэл, барьцааны мөнгө байрлуулснаар үүнд зээлийн санхүүжилт шиг тодорхой хэмжээний хүү бодогдох бөгөөд тодорхой нөхцөлүүдийг хангасан тохиолдолд барьцааны хөрөнгийг хөрөнгө оруулалт болгон шилжүүлж хүү тооцохоо больдог.

Зээл болон хөрөнгө оруулалтын санхүүжилт нь бусад бүх төрлийн санхүүжилтийн суурь болдог. Ерөнхийдөө аливаа үйл ажиллагааг хөрөнгө оруулалт хийж санхүүжүүлэх нь илүү өндөр эрсдэлтэй боловч мөн илүү ашиг олох боломжтой. Эсрэгээрээ, зээлийн санхүүжилт хийснээр барьцаа болон бусад тохиролцсон нөхцөлөөр харьцангуй эрсдэл багатай байдаг бөгөөд хөрөнгө оруулалттай харьцуулбал буцаан төлөлт нь хурдан боловч үүнээс ирэх ашиг нь харьцангуй бага.

Хосолсон санхүүжилт гэдэг нь төсвийн болон донор, хандивын (буцалтгүй тусламж болон үүнтэй ижил төстэй хөрөнгө) хөрөнгийн хувийн болон арилжааны бүтээгдэхүүнтэй хослуулан хийхийг хэлнэ.



Гэрэл зургийг Алтны бичил уурхайн зөвлөл

Хувийн санхүүжүүлэгч байгууллагууд зарим нэг үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эсвэл хийсэн санхүүжилтээ өргөжүүлэх сонирхолгүй байж болох юм. Ийм тохиолдолд тулгарч болзошгүй эрсдэлийг хувааж үүрэх, санхүүжүүлэгч байгууллагын ашиг орлогыг хэвийн байлгах зорилгоор холимог санхүүжилт хийж зохицуулах боломж байдаг. Жишээлбэл, Засгийн газраас арилжааны банканд алтны бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн зээлэнд нь баталгаа гаргаж болох юм. Эсвэл хөгжлийн болон донор байгууллагууд бичил уурхайн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хөрөнгө зарцуулж ажилласнаар тэдний үйл ажиллагаа сайжирч, арилжааны банкуудаас зээл авах, бизнесийн хөрөнгө оруулалтыг татах боломжийг нэмэгдүүлнэ. Хосолсон санхүүжилтийн гол зорилго нь эдийн засгийн ашигтай, нийгэм болон байгаль орчны хариуцлагатай, их хэмжээгээр эерэг нөлөө үүсгэх боломжтой бизнесийг хөгжүүлэхэд оршдог. Ийм төрлийн санхүүжилтийг хийснээр цаг хугацааны дараа тухайн бизнесийн байгууллага өсч хөгжин хувийн санхүүжүүлэгч байгууллагуудын тэдэнд итгэх итгэл батжин хамтарч ажиллах, хэвийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болсноор цаашид төрийн зүгээс зарцуулах хөрөнгийн хэмжээ буурна гэж үздэг.

Жижиг бизнесийн санхүүжилтийн өөр нэг төрөл нь **лизинг буюу зээлээр** авах юм. **Лизинг** гэдэг нь зээлдэгч этгээд байшин барилга, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж гэх мэт тодорхой биет хөрөнгийг тодорхой хугацаанд цувуулан төлөх нөхцөлтэйгөөр зээлэн авч ашиглахыг хэлнэ. Зарим тохиолдолд тухайн эд хөрөнгийг зөвхөн түрээсэлж ашиглах нөхцөлтэйгөөр лизинг хийдэг бөгөөд зээлдэгч тухайн хөрөнгийг зөвхөн ашиглах эрхтэй, түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлөх ба зээлдүүлэгч уг хөрөнгийн эзэмшигч байна. Харин зарим тохиолдолд зээлдэгч тухайн эд хөрөнгийн үнийг цувуулан төлж дууссан тохиолдолд эзэмших эрх зээлдэгчид шилжихээр тохирч болдог.

2.2 Нөхцөл боломж муутай салбарын санхүүжилтийн бүтэц

Хөгжил буурай гэж үздэг салбарын хувьд санхүүжилтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилготой санхүүжилтийн хэд хэдэн бүтэц байдаг бөгөөд энэ нь арилжааны банкнаас зээл авахад шаардагдах барьцаа хөрөнгө дутмаг байх, үйл ажиллагаанд өндөр эрсдэл тулгарах гэх мэт санхүүжилт хийхэд нийтлэг тохиолддог саад тотгорыг бууруулахад чиглэдэг.

Жишээлбэл, зээлийн санхүүжилт дараах бүтэцтэй байна. Үүнд:

► Төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хийдэг **концессын буюу хөнгөн нөхцөлтэй зээл** нь зах зээлийн жишгээс бага хүүтэй, хөрөнгийн үнэлгээ бага, эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжтой, эсвэл барьцаа хөрөнгийн харьцангуй сул шаардлага гэх мэт харьцангуй зөөлөн нөхцөлтэй байдаг. Концессын зээлийг ихэвчлэн Засгийн газраас болон донор байгууллагын хөтөлбөрөөс олгодог. Ийм төрлийн санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулж хийснээр тухайн салбарын хувьд чадавх бэхжүүлэх, туршлага хуримтлуулах, нийгмийн дунд байр сууриа батжуулах боломжийг бүрдүүлж өгдөг.

► **Зээлийн эргэлтийн сан** нь өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг уг санд байрлуулснаар бусад хүмүүст шинээр зээл олгох боломжтой болдог. Зээлийн эргэлтийн санг ихэвчлэн донор байгууллагын хөрөнгөөр үүсгэдэг бөгөөд уламжлалт журмаар арилжааны банкнаас зээл авах нөхцөлийг хангах боломжгүй хүмүүст чиглэж байгуулдаг. Ялангуяа, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хувьд зээлийн эргэлтийн санг байгуулж ажиллуулахад орон нутгийн иргэд, удирдлагын оролцоо хүчтэй байхаас гадна зээлдэгчийн эрх мэдэл нэмэгдэж нийгмээрээ чадваржих боломж бүрддэг. Зээлийн эргэлтийн сангаас зээл авах хүсэлт гаргах үйл явц хялбар, хөрөнгийн барьцаа гаргах арга хэлбэр, шаардлага нь энгийн, хангаж болохуйц байдаг. Түүнчлэн, зээлийн эргэлтийн сангийн болон зээлдэгчийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажилласнаар зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлдэг.

► **Эрсдэлийг хамтран үүрэх хөтөлбөр** нь батлан даагч (ихэвчлэн засгийн газар, донор байгууллага, ТББ) болон хөрөнгө нийлүүлэгч нар зээлийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтэд тулгарч болзошгүй эрсдэлийг хамтран үүрэхээр тохиролцож хэрэгжүүлдэг үйл ажиллагаа юм. Энэ тохиролцооны дагуу эрсдэл үүссэн тохиолдолд батлан даагч албан ёсоор учирсан хохирлын

тодорхой хэсгийг зээлдүүлэгчид нөхөн төлөх арга хэмжээг хэрэгжүүлдэг.

2.3 Албан ёсны хөрөнгө оруулагчдын ангилал

Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд албан ёсоор хөрөнгө оруулагчдыг дараах байдлаар ерөнхийд нь ангилна. Үүнд:

Зээлийн санхүүжилт

► **Бичил санхүүжилт** нь хөгжил буурай салбарт оруулдаг жижиг санхүүжилтийн хамгийн нийтлэг хэлбэр юм. Бичил зээл олгогчид нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Ийм санхүүгийн үйлчилгээнд зээлээс гадна зарим тохиолдолд даатгал болон барьцаа хөрөнгө гэх мэт бусад үйлчилгээ багтдаг.

► **Орон нутгийн хуримтлал ба зээлийн багцууд.** Зарим газар алтны бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор орон нутгийн хуримтлал үүсгэж зээл олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг. Ийм сан байгуулахад тухайн орон нутгийн иргэдийн байгууллагын гишүүн бүр хувь нэмэр оруулдаг бөгөөд ингэж бүрдүүлсэн хуримтлалаас гишүүдэд шаардлагатай зээлийг нь олгодог. Харин зээлийн хүүгээр гишүүдийн үүсгэсэн үндсэн хуримтлалыг зузаатгадаг байна.

► **Арилжааны банк.** Банкууд бизнесийн үйл ажиллагаанд зээл олгох, хөрөнгө оруулалтын багцуудыг санал болгох гэх мэт санхүүжилтийн үйлчилгээг үйлчлүүлэгчдэдээ хүргэдэг. Арилжааны банкууд дэлхийн, үндэсний болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж болох бөгөөд тодорхой дүрэм журам, стандартын дагуу ёс зүйн дүрмийг баримтлан ажилладаг. Түүнчлэн банкууд үйлчлүүлэгчид болон хувьцаа эзэмшигчдээ төлөөлж тэдний оруулсан хөрөнгө оруулалтад тулгарч болзошгүй эрсдэлийг зохицуулах үүрэгтэй байдаг нь тэдний хувьд эрсдэлтэй бизнест хөрөнгө оруулахаас зайлсхийх гол шалтгаан болдог байна.

► **Хамтарсан (хоршооллын) банкууд** нь гишүүд, хувь эзэмшигчдэдээ санхүүгийн үйлчилгээ хүргэдэг. Тэд ихэвчлэн жижиг бизнесүүдэд үйлчлэх тусгай чиг үүрэгтэй байдаг.

► **Үндэсний хөгжлийн банкууд.** Үндэсний хөгжлийн банкууд (ҮХБ)-ыг эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Засгийн газраас байгуулдаг. Тэдний гол үүрэг нь үйлдвэрлэл, хөдөө аж ахуй болон бусад үйлдвэрлэлийн салбарт дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалт хийх юм. Тэдний хувьд гол чиг үүрэг нь эдийн засгийн хөгжлийг дэмжих учраас хөрөнгө оруулалт нь арилжааны банкнаас арай богино хугацаатай байдаг.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт

► **Хувийн хөрөнгө оруулагчид.** Хувийн хөрөнгө оруулагчид (ХХО) гэдэг нь шууд хөрөнгө оруулж байгаа хувь хүн болон хамтран ажилладаг бүлэг хүмүүсийг хэлнэ. Түүнчлэн хувийн хөрөнгө оруулагчид нь хязгаарлагдмал эрхтэй гишүүдийн хөрөнгө оруулалтаас бүрдсэн сангаас хөрөнгө оруулж болно.

► **Нөлөөллийн хөрөнгө оруулагчид** нь нийгмийн болон байгаль орчны асуудлаар хэмжигдэхүйц эерэг нөлөө гаргахаас гадна санхүүгийн хувьд ч ашигтай ажиллахыг шаарддаг. Хувийн хэвшлийн болон төрийн байгууллагаас нөлөөллийн хөрөнгө оруулалт хийж болдог. Ийм санхүүжилтийг зээл олгох болон хөрөнгө оруулах хэлбэрийн аль ч хэлбэрээр нь хийж болно. Нөлөөллийн хөрөнгө оруулалтын ач холбогдол нь үүнээс ашиг орлого олохдоо гол нь биш, харин эхний оруулсан хөрөнгийн хэмжээг багасгалгүй түүнээс эерэг үр дүн, нөлөө гаргахыг санал болгодогт оршино. Нөлөөллийн хөрөнгө оруулагч гэдэгт тусгай сан, хөгжлийн санхүүжилтийн байгууллагууд, гэр бүлийн бизнес, хөрөнгө ихтэй хувь хүмүүс болон цөөн тооны тэтгэврийн сан багтдаг.

3. Алтны бичил уурхайн санхүүжилтийн дэлхий нийтийн туршлага

Сүүлийн жилүүдэд Засгийн газрууд, хөгжлийн байгууллагууд, ТББ-ууд болон хэд хэдэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчид алтны бичил уурхайн үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтын хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн. Энэхүү туршлага нь алтны бичил уурхайн үйл ажиллагаанд оруулах албан ёсны хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэхэд шаардлагатай арга барил, хандлага болон тулгарсан саад бэрхшээл, үүнийг даван туулахад хувь нэмэр оруулахуйц сургамжийг бий болгосон.

3.1 Албан бус санхүүжилт

Албан ёсоор санхүүжилт авах боломж дутмагаас шалтгаалж бичил уурхайчид ихэвчлэн албан бус санхүүжилтийн эх үүсвэртэй холбогдож ирсэн. Эдгээр “зуучлагчид”-ыг ихэвчлэн “шударга бус”¹ хүмүүс гэж нэрлэдэг бөгөөд өөрсдийн монополь байр суурийг ашиглаж шударга бус тохиролцоо хийдэг гэж үздэг. Санхүүжилт хийх өөр эх үүсвэр дутмаг байгааг үл харгалзан олон хүмүүс энэ төрлийн санхүүжүүлэгчдийн үйл ажиллагааг зогсоох нь зүйтэй юм гэж үзэж байсан.² Нөгөө талаар эдгээр зуучлагчид нь алтны бичил уурхайн үйл ажиллагааны маш чухал хөдөлгөгч хүч байж болох юм. Албан болон албан бус үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчид эдгээр зуучлагчдаас үргэлжлүүлэн санхүүгийн дэмжлэг авсаар байгаа нь тэдний хувьд санхүүгийн бусад эх үүсвэр маш бага, энэ талаар тухайн улсын төр засаг болон албан ёсны санхүүжилтийн байгууллагуудад найдлага тавихгүй байгаагийн илрэл юм. Иймээс тэдгээр зуучлагчдын үзүүлж байгаа санхүүгийн үйл ажиллагааг албан ёсны санхүүжилтээр орлуулах оролдлого хийвэл энэхүү удаан хугацааны туршид итгэлцэлд суурилан хамтран ажилласан бизнесийн холбоо, орон нутгийн ард иргэдийн хоорондын хамтын ажиллагаа, итгэлцлийн сүлжээ (эдгээр албан бус санхүүжүүлэгчдийн үйл ажиллагааг хууль бус үйл ажиллагаа гэж албан ёсоор үзээгүй тохиолдолд) зэргийг харгалзан үзэж зохицуулах шаардлагатай.

3.2 Бичил санхүүжилт

Бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэд хэдэн улсад бичил санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Тухайлбал, Папуа Шинэ Гвинейд бичил уурхайг төлөвшүүлэх зорилгоор хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бичил санхүүжилтийн санаачилгуудыг хэрэгжүүлж ирсэн байна. Бичил санхүүжилтийн хамгийн амжилттай хэрэгжсэн стратегийн нэг нь зээлдүүлэгчдэд тулгарч болзошгүй эрсдэлийг хамтран үүрэх арга бөгөөд энэ нь алтны бичил уурхайн салбарын өндөр эрсдэлийн талаарх банкууд, донор байгууллагууд ба зээлдүүлэгчдийн хандлагыг өөрчлөх үр дүнтэй арга юм. Жишээлбэл, Гана Улсын Болгатанга болон Тонгод амжилттай хэрэгжүүлсэн “бүлгээр хамтрах” бичил санхүүжилтийн зарчим юм. Үүнийг өөрийн хүсэлтээр сонгогдсон 5-10 гишүүн бүхий бүлгийн зохион байгуулалтад оруулсан бөгөөд бүлгийн гишүүдийг дотор нь санхүүгийн боломжоор нь эрэмбэлж хуваарилах зарчмаар хийсэн байна.

1 Африкийн Холбоо, 2009. Африкийн уул уурхайн алсын хараа. Африкийн Холбоо, Аддис Абаба; Дэлхийн банк, 2012. Онцгой экологийн систем дэх бичил уурхайн үйл ажиллагаа: Габоны байдал, Либериа ба Мадагаскар. Дэлхийн банк, Вашингтон ДС; Виллегас С., Вейинберг Р., Левин И., Ханд К. 2012. Тусгай хамгаалалтын бүс нутаг болон онцгой экологийн системд байрладаг бичил уурхайн үйл ажиллагаа хөтөлбөр (ASM-PACE): Даян дэлхийн шийдэл. WWF, Дар Эс Салаам; “Бичил уурхай гэж юу вэ?”, <http://chambersfederation.com/what-is-asm/> (Accessed 2 June 2019);

2 Хенчел et al., 2002 үзнэ үү; Карстенс Ж. 2017. Бичил уурхай ба Европын Холбоо ба ашигт малтмалын баялаг бүхий хөгжиж байгаа орнуудын хамтын ажиллагаанд үүнээс үзүүлж байгаа ач холбогдол. Европд түүхий ашигт малтмал нийлүүлэх стратегийн хэлцэл, Horizon 2020 хөтөлбөр, ЕХ, Бруссел.

Авсан зээлийн хэмжээг нь тодорхойлох зорилгоор гишүүдийг эрэмбэлжээ.³ Энэ ажил харьцангуй амжилтад хүрсэн боловч үүний хажуугаар зарим бичил уурхайчид шаардлага хангаагүй, чанаргүй төхөөрөмж өгсөн тухай асуудал дэвшүүлсэн байна.⁴ Мөн түүнчлэн Танзани,⁵ Никарагуа⁶ болон Суданд⁷ бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бичил санхүүжилт хийсэн талаар туршлага хуримтлагджээ.

3.3 Засгийн газраас хэрэгжүүлсэн санхүүжилтийн багцууд

Хөгжиж буй зарим орнуудын арилжааны банкууд бичил уурхайн үйл ажиллагаанд холбоотой бизнесийн байгууллагуудад санхүүжилт хийх чиглэлээр ажилласан туршлага байдаг. Гэсэн хэдий ч эдгээр зээлийн ихэнх нь өндөр барьцаа хөрөнгө шаарддаг бөгөөд өндөр хүүтэй, эргэн төлөлтийн нөхцөл нь маш хатуу байснаас гадна зарим тохиолдолд 1 сая ам.доллар хүртэл эхний хөрөнгөтэй байх ёстой гэх мэт шаардлага тавьдаг байжээ.⁸ Иймээс зөвхөн шаардлагуудыг хангасан, эсвэл танил тал, холбоо сүлбээ ихтэй цөөн тооны хүмүүс л эдгээр санхүүжилтээс авах боломжтой байсан.

Бичил уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор зарим улсын Засгийн газраас шууд зээл олгох, эсвэл зээлийн баталгаа гаргах гэх мэт төрөл бүрийн санхүүжилтийн хэлбэрүүдийг туршиж хэрэгжүүлсэн нь бас л төрөл бүрийн үр дүнд хүрчээ. Эдгээр оролдлогуудын зарим нь бүтэмжгүй болсон нь бичил уурхайчид авсан зээлээ буцаан төлөх чадваргүй байсан бол зарим тохиолдолд хэтэрхий их барьцаа хөрөнгө шаардсан хатуу нөхцөлтэй байснаас зээлийн шаардлага хангасан хүн байхгүй байснаас шалтгаалсан байна.

Хэд хэдэн улс уул уурхайн үйл ажиллагааг дэмжих сан байгуулж туршиж үзжээ. Эдгээр санг үндэсний хөгжлийн төсвөөс бүрдүүлсэн бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр, экспортын ашиг болон уул уурхайн бүтээгдэхүүний худалдаа, түрээсийн орлогоор зузаатган бүрдүүлсэн байна. Эдгээр санг байгуулж хэрэгжүүлснээр мөн л төрөл бүрийн шалтгаантай холимог үр дүнд хүрчээ. Жишээлбэл, Мозамбикийн Fundo de Fomento Mineiro сан нь үйл ажиллагааны доголдлоос шалтгаалж ашигт малтмалын гарцыг тогтмол байлгах боломжгүй байдалд хүрсэн уурхайчид зээлээ эргэн төлж чадаагүйгээс амжилтгүй болсон. Харин Намибийн ашигт малтмалын хөгжлийн сан тэдэнд шаардлагатай хэмжээний санхүүжилт өгөхгүй байна хэмээн бичил уурхайчид гомдол гаргаж байжээ.⁹ Бичил уурхайчид 16.5 сая фунт стерлингийн санг ашиглаж чадаагүй бөгөөд шалтгаан нь санхүүжилт авахад тавьсан хэт өндөр шаардлагад нийцээгүй байна.

Бичил уурхайчид авсан зээлээ эргүүлэн төлж чадаагүйгээс эцэст нь Өмнөд Африкийн уул уурхайн санг татан буулгасан. Энэ сангийн тухайд цагаа олоогүй үйл ажиллагаа байсан гэж үзэж болох талтай. Учир нь үүнийг нээх үед тухайн улсад улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал үүссэнээс Засгийн газар зээлдэгчдийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, тэр ч байтугай зээлийн хүсэлтүүдийг зохих журмын дагуу шалгах, судлах боломжгүй байсан тул ийм үр дүнд хүрсэн гэж үздэг. Гана Улсын уул уурхайн санг улсын эрдэс баялгийн хөгжлийн сангаас санхүүжүүлдэг байсан бөгөөд “бүлгээр зээлдэх” аргаар хэрэгжүүлсэн. Эндээс санхүүжилт авахын тулд бичил уурхайчид хоршооллын зохион байгуулалтад орж зээлийн гэрээний заалтын дагуу хамтран ажиллахыг шаарддаг.

3 Mainsah, E., Heuer, S.R., Kalra, A., Zhang, Q. 2004. Грамзэн банк: Эмзэг бүлэгт хөрөнгийг хүртээх нь. Колумбийн бизнесийн сургууль, Колумбийн их сургууль, New York.

4 Hilson ба Ackah-Baidoo, 2011. Африкийн бичил уурхайчдын үйл ажиллагааны хүндрэлтэй асуудлыг бичил санхүүжилтийн үйлчилгээ шийдвэрлэх үү? Дэлхийн хөгжил 39: 1191-1203.

5 Тан Дисковери. 1996. Бичил уурхайн салбарын хөгжлийн стратеги боловсруулах бэлтгэл ажиллагаа болон нөхцөл байдлын судалгааны эцсийн тайлан. Дэлхийн банканд зориулан бэлтгэсэн тайлан, Вашингтон ДС

6 D'Souza, K. 2000. Бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих загвар хөтөлбөрийн дизайн ба туршилтын I үе шат. Их Британийн олон улсын хөгжлийн газарт хүргэсэн тайлан. Лондон хот.

7 Spiegel, S. 2012. Африкийн бичил санхүүжилтийн үйлчилгээ, ядуурал ба бичил уурхайн үйл ажиллагаа: Эмзэг бүлгийн хүмүүсийг хөгжүүлэх арга хэмжээг эрэлхийлэх нь. Олон Улсын хөгжлийн журнал 24: 485-517

8 Hilson, G., Hilson, A., Adu-Darko, E. 2014. Гана Улсын албан бус алтны уурхайн эдийн засагт Хятад Улсын оролцоо: Хөдөлгөгч хүч, хамаатай асуудал болон тодруулга. Хөдөөгийн судалгаа журнал 34: 292-303

9 “Бичил уурхайчид SOS дохио өгч байна”, <https://economist.com.na/2666/headlines/small-scale-miners-send-sos-signal/> (2019 оны 6 сар)

Засгийн газраас зээл олгодог боловч үйлдвэрлэл эхэлтэл зээлийн эргэн төлөлт хийгддэггүй. Тусгай зөвшөөрөл бүхий алт худалдан авагч зээлийн эргэн төлөлтийн баталгаажуулагчийн үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд түүний гол үүрэг нь бичил уурхайчид олборлосон ашигт малтмалаа худалдах бүрд түүнээс олсон орлогоос тодорхой хэмжээний мөнгийг зээлийн эргэн төлөлтийн санд шилжүүлэх байв.¹⁰ Энэ хөтөлбөрийн хэрэгжилт өмнөхийн адил холимог үр дүнд хүрсэн. Нэг хотод харьцангуй амжилттай хэрэгжиж, үр дүн гаргасан бол нөгөө хотод бүлэг, хамт олны дотоод зөрчил хурцадмал байдалд хүрч эцэст нь үйл ажиллагааг нураахад хүрсэн.



Алтны бичил уурхайн салбарт Засгийн газраас үзүүлсэн дэмжлэгийн хамгийн түгээмэл хэлбэр нь тоног төхөөрөмжөөр хангах, түрээслүүлэх хөтөлбөр юм. Гэсэн хэдий ч эдгээр оролдлогын ихэнх нь эргэн төлөлтөө цаг хугацаанд нь хийгээгүй, тоног төхөөрөмжийн эвдрэл болон хяналт шалгалт тогтмол хийгээгүй гэх мэт шалтгаанаар амжилтад хүрээгүй юм.

Бичил уурхайн салбарт Засгийн газраас хэрэгжүүлсэн санаачилгуудаас хамгийн амжилттай, үр дүнтэй хэрэгжсэн нь Чили Улсын Үндэсний уул уурхайн компанийн (ENAMI) туршлага юм. Энэ компани нь төрийн өмчийн аж ахуйн нэгж бөгөөд бичил, дунд хэмжээний уурхайн үйл ажиллагаанд санхүүжилт, техник туслалцаа, ашигт малтмалын худалдаа болон бизнесийн сургалт, чадавх бэхжүүлэх чиглэлээр үйлчилгээ хүргэдэг байгууллага. Компанийн зүгээс эдгээр үйл ажиллагааг явуулах санхүүжилтээ алтны хүдэр худалдан авч баяжуулах болон уул уурхайн компаниудтай хамтран ажилласан орлогоос гаргадаг. Дэлхийн банк болон бусад хөгжлийн байгууллагуудаас энэ туршлагыг загвар болгон бусад улсуудад зөвлөмж болгодог байна.

Эдгээр туршлагаас харахад улс орнуудын Засгийн газруудаас бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх талаар багагүй санаа тавьж ирсэн нь илэрхий байна. Хэдийгээр донор байгууллагуудаас энэ үйл ажиллагааг хурдасгахад тусламж, дэмжлэг үзүүлж ирсэн боловч үүнтэй холбоотой ложистикийн ажлыг ихэвчлэн Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж гүйцэтгэснийг харахад энэ ажлыг хийх боломжгүй гэж үзэх үндэслэлгүй юм. Үүнээс гадна бас нэгэн тэмдэглүүштэй зүйл бол эдгээр санаачилгууд ихэвчлэн уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжилд илүү их ач холбогдол өгдөг улс орнуудын Засгийн газраас гарсан бөгөөд эдгээр улс орон бичил уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэхэд ч багагүй анхаарал тавьж байгаа нь өөрөө их чухал юм. Харамсалтай нь эдгээр улс орнуудын цөөнх нь л удаан хугацаанд энэхүү санаачилгаа тогтвортой авч хэрэгжүүлсэн юм. Тэдэнд бичил уурхайчдын зээлийн эргэн төлөлтийн хэмжээнд мониторинг хийх, түрээсэлсэн тоног төхөөрөмжийн зохистой ашиглалтыг баталгаажуулах гэх мэт орон нутгийн түвшний менежментийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна. Түүнчлэн эдгээр санаачилгыг хэрэгжүүлж эхлэх шатанд тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтний туршлага дутмаг байснаас шаардлага хангахгүй, чанаргүй тоног төхөөрөмж худалдан авах, туршлагагүй талуудтай хамтарч ажиллах гэх мэт үндсэн алдаа дутагдал гаргаж байсан байна. Ийм үйл ажиллагааг амжилтад хүргэхэд төрийн болон донор байгууллагуудын удаан хугацааны тогтвортой оролцоо маш чухал үүрэгтэй. Тухайн санд орон нутгийн арилжааны ашгаас орсон орлого гэх мэт анхны хөрөнгөөс бусад нэмэгдэл санхүүжилтийг зохицуулахад засгийн газруудын хувьд хүндрэл учирч байсан байна.

10 Хилсон ба Ака-Бэйдү, 2011.

3.4 Холимог санхүүжилт

Уул уурхайн үйл ажиллагаанд зориулсан улсын төсөв болон бусад сангаас гадна улс орнуудын Засгийн газрууд болон донор байгууллагууд хамтран холимог санхүүжилт хийх хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн. Африкийн батлан даалтын сан (AGF) санхүү болон хөрөнгө оруулалтын байгууллагуудтай хамтран төрөл бүрийн салбарын жижиг, дунд бизнесийн байгууллагуудын зээл болон бусад санхүүжилтийн бүтээгдэхүүнд баталгаа гаргах чиглэлээр ажилладаг. 2017 онд Африкийн батлан даалтын сан Европын холбооны АСР эрдэс баялгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллахыг зөвшөөрч Камерун, Гвиней (Конакри), Уганда, Нигери болон Замбийн санхүүгийн байгууллагуудад ашигт малтмалын салбарын жижиг, дунд бизнесийн зээл олгоход баталгаа болгож 12 сая ам.долларын сан бүрдүүлсэн. Түүнчлэн, энэхүү хөтөлбөрт Африкийн батлан даалтын сан болон Европын холбооны АСР эрдэс баялгийн хөгжлийн хөтөлбөр хамтран санхүүгийн байгууллагуудад зориулж оролцоог хангасан санхүүжилт болон бизнес эрхлэхэд шаардлагатай ур чадварын сургалт зохион байгуулах ажлыг тусгажээ.¹¹ Энэхүү хөтөлбөр нь санхүүжилт шаардлагатай бизнесийн байгууллагуудад хадгаламж, зээлийн хоршоо, арилжааны банктэй хамтран санхүүжилт шаардлагатай бизнесийн байгууллагуудад зээл олгох чиглэлээр ажилласан. Эдгээр санхүүгийн байгууллагууд Засгийн газар болон бусад хөтөлбөртэй хамтран ажиллаж, олборлолтын үйл ажиллагаа, байгаль орчин, нийгмийн болон бусад шаардлагуудыг хэрхэн дагаж мөрдөн, хангаж байгаад хяналт тавих чиглэлээр ажилладаг.

Танзани Улсын банк дотоодын албан ёсны үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй арилжааны банкуудаар дамжуулан 500 сая шиллинг (ойролцоогоор 200 мянган ам.доллар) хүртэлх зээлийн баталгаа гаргаах аяхан амласан. Энэхүү хөтөлбөр нь Дэлхийн банкны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн баталгааны хөтөлбөртэй (SME-CGS) хамтарсан бөгөөд бичил уурхайчдын авсан 5 хүртэлх жилийн хугацаатай зээлийн барьцааны 50 хувийг гаргах зорилготой юм.¹²

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанаас бичил уурхайчид мөн ашиг шим хүртсэн туршлага бий. Перу Улсын Sotrami S.A. бичил уурхайчдын байгууллага нь анх 165 гишүүнтэйгээр бичил уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол одоо 1000 гаруй гишүүдтэй болж¹³ хувийн салбарын санхүүжилтийн байгууллага болон нөлөөллийн санхүүжилтийн сангаас 1.3 сая ам.долларын зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна. Зээлийн гэрээний нөхцөлд Sotrami Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) болон Швейцарын хөгжлийн агентлагтай (ШХА) хамтран хүүхдийн хөдөлмөрийг бичил уурхайн үйл ажиллагаанаас халах чиглэлээр ажиллах шаардлага тавьсан.¹⁴ Энэ хамтын ажиллагаа улам гүнзгийрч Сайн алт санаачилга болж өргөжсөн. Энэ санаачилга нь Швейцарын Холбооны Улсын Засгийн газрын санхүүжилтээр алтны бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг сайжруулж тэдний бүтээгдэхүүнийг Швейцарын хувийн салбарын алт худалдан авагчидтай холбох чиглэлээр ажиллажээ. Түүнчлэн уг санаачилга нь тодорхой стандартын шаардлагыг хангаж ажилласан бичил уурхайчдын олборлосон алтыг худалдан авахдаа бага зэрэг урамшуулал нэмж төлдөг ба үүнийг бичил уурхайчдын хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах нөхцөлтэй юм.

3.5 Хөрөнгө оруулагчид

Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд шууд хөрөнгө оруулалт хийсэн туршлага цөөн байдаг. Тэдний нэг болох Холбоодын танхим нэртэй нөлөөллийн хөрөнгө оруулагч байгууллага Кени Улсын алтны бичил уурхайд анх хөрөнгө оруулсан бөгөөд энэ туршлагаа 2017 онд Ардчилсан Конго Улсад Шударга Конго санаачилгыг хэрэгжүүлэхэд ашигласан. Шударга Конго нь зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг цор ганц зөрчилгүй алтны бичил

11 Африкийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих батлан даалтын сан (AGF) болон Европын холбооны АСР-EU эрдэс баялагийн хөгжлийн хөтөлбөр Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан: www.developmentminerals.org/index.php/en/training/events/17-regional/176-signing-of-a-memorandum-of-understanding-mou-between-the-african-guarantee-fund-for-small-and-medium-sized-enterprises-agf-and-the-asf-eu-development-minerals-programme (2020 оны 4 дүгээр сар).

12 "Танзани улс: Танзанийн банк бичил уурхайчдын зээлийн барьцаа рапраж байна", <https://allafrica.com/stories/201909270104.html> (Accessed 3 October 2019).

13 "Нөлөөллийн Санхүүжилтийн сан", <http://www.impact-finance.com/> (2020 оны 4-р сар).

14 "БИЧИЛ УУРХАЙЧНЫ ТҮҮХ: ЮЖЕНИО ЮАХУА ВЕРА, СОТРАМИ S.A., ПЕРУ", <https://www.levinsources.com/knowledge-centre/insights/a-miners-story-eu-genio-huayhua-vera-sotrami-s-a-peru> (2020 оны 1 сарын 4).

уурхайн нийлүүлэлтийн сүлжээ хэмээн Холбооны танхимаас баталдаг.

Саяхан Канадын Тогтвортой эдийн засгийн ирээдүй бүлэг Цэвэр алт нийгмийн шийдэл загварыг (SEF Clean Gold),¹⁵ боловсруулсан бөгөөд энэ хөтөлбөрөөр 1,500,000 ам.долларын хөрөнгө босгож Эквадорын бичил уурхайн баяжуулах байгууламжуудыг дэмжих хариуцлагатай хөрөнгө оруулалтын холбоо байгуулсан. Өнөөг хүртэл алтны бичил уурхайн салбарт хөрөнгө оруулалт маш бага байжээ.

3.6 Уул уурхайн салбарын бизнесийн зохион байгуулалт

Алтны бичил уурхайн бизнесүүд болон дунд, том уурхайн компаниуд гэх мэт уул уурхайн үйлдвэрлэлийн бусад оролцогч талуудын хоорондын харилцаа холбоо бичил уурхайн үйл ажиллагаанд, ялангуяа нэг бүс нутагт зэрэгцэн оршиж үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиромжтой эх үүсвэр юм. Орон нутгийн тэргүүлэгч үйлдвэрлэгчид нь бизнесийн үйл ажиллагааг сайн мэддэг бөгөөд алтны бичил уурхайчидтай нэг бүс нутагт зэрэгцэн үйл ажиллагаа явуулах боломжтой байдгаас бичил уурхайн үйл ажиллагааг илүү ойлгож мэдэх бөгөөд энэ нь тэдэнд тулгарах эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой байж болох юм. Үүнээс хоёр талд харилцан ашигтай “ялах-ялах” нөхцөл буюу хамтарсан үйлдвэрлэл эрхлэх, эсвэл үйл ажиллагааны зохицуулалт хийж ажиллах нөхцөл бүрдүүлж болно. Зарим уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хөтөлбөрийн хүрээнд бичил уурхайчдыг дэмжих сан байгуулах, эсвэл экспертийн үйлчилгээ хүргэх хэлбэрээр дэмжиж ажилладаг. Гэхдээ ийм төрлийн дэмжлэгийг бичил уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэхээсээ илүү тухайн орон нутгийн зүгээс үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахын тулд үзүүлж байх талтай. Зарим тодорхой бүс нутагт уул уурхайн төрөл бүрийн түвшний аж ахуйн нэгжүүд хоорондоо бизнесийн холбоо үүсгэн ажиллах уламжлалт хамтын ажиллагааг үүсгэх тохиолдол байдаг. Гаяна, Гана болон Танзани улсад үйл ажиллагаа нь амжилттай яваа дунд хэмжээний уурхайн компаниуд байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах, үйлдвэрлэсэн алтыг нь олборлолтын газар дээр нь худалдан авах, бичил уурхайчдад өөрийн тоног төхөөрөмж болон баяжуулах цехээ ашиглахыг зөвшөөрөх, зөвшөөрөлтэй газрынхаа зарим хэсэгт ажиллах боломж олгох гэх мэт үйлчилгээ, тусламж, дэмжлэгүүдийг үзүүлж ирсэн байна.^{16 17}

Перу Улсын Солидаридад ТББ зуучилснаар Минера Янакиа дунд хэмжээний уурхайн компани болон бичил уурхайчдын байгууллага хоёр хамтран ажилладаг бөгөөд энэ хөтөлбөрийн хүрээнд олборлолт, аюулгүй ажиллагааны нөхцөл байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, зарим орон нутгийн бичил уурхайчидтай бичил гэрээ байгуулан тэдний олборлосон хүдрийг компанийн хүдэр баяжуулах цехэд мөнгөн усгүй технологи ашиглан баяжуулах гэх мэт хамтарсан үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү харилцаа, хамтын ажиллагаа нь өнгөрсөн арван жилийн хугацаанд ихээр нэмэгдээд байгаа албан ёсны эрх бүхий хүдэр баяжуулах төвлөрсөн байгууламжууд бичил уурхайчдын олборлосон хүдрийг худалдан авч баяжуулах үйл ажиллагаатай уялдаж байгаа юм. Мөн түүнчлэн жижиг хэмжээтэй баяжуулах цехүүд нь бичил уурхайчдын хувьд төрөл бүрийн үйлчилгээ авах бааз, нэг цэгийн үйлчилгээний газар болдог. Жишээлбэл, Зимбабве Улсын Шамва тосгонд хүдэр баяжуулах цех байгуулснаар өмнө нь гол дагаж алт угаан мөнгөн ус ашиглаж байсан нутгийн бичил уурхайчид ирж үйлчлүүлэн амжилттай хамтран ажилласан байна. Эдгээр бичил уурхайчид төвлөрсөн орчинд амальгам хийхийг дэмждэгээс гадна эндээс техникийн болон байгаль орчны чиглэлийн сургалтуудад хамрагддаг болжээ. Яваандаа энэ баяжуулах цехийн бөмбөлөгт тээрмийн хүчин чадал бага байснаас их хэмжээний хүдэр баяжуулах боломжгүй зэрэг шалтгаанаар үйл ажиллагаа нь зогссон.¹⁸ Зарим баяжуулах үйлдвэрт бичил уурхайчид олборлосон хүдрээ мөнгөн усны амальгам хийж баяжуулаад үүнээс гарсан алтны тодорхой хэмжээний агуулга бүхий хаягдлыг баяжуулах цехэд үлдээх зарчмаар ажилладаг байна. Энэхүү алтны агуулга бүхий хаягдлыг цех дахин баяжуулж ашиг олдог.

15 “Цэвэр алт нийгмийн шийдэл”, www.sefcleangold.com (2020 оны 4-р сар).

16 Бичил уурхайн эксперттэй хийсэн ярилцлага, Гаяна, 2019 оны 5 сарын 3; Бичил уурхайн эксперттэй хийсэн ярилцлага, Гаяна, 2019 оны 5 сарын 23; Бичил уурхайн эксперттэй хийсэн ярилцлага, Танзани, 2019 оны 5 сарын 18.

17 Бичил уурхайн эксперттэй хийсэн ярилцлага, Гаяна, 2019 оны 5 сарын 1; Бичил уурхайн эксперттэй хийсэн ярилцлага, Буркина Фасо, 2019 оны 5 сарын 4.

18 НҮБ-ын Африкийн Эдийн Засгийн Комисс (UNECA). 2002. Африкийн бичил уурхайн сайн туршлагын нэгтгэл. НҮБ-ын Африкийн Эдийн Засгийн Комисс, Аддис Абаба

4. Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд албан ёсоор санхүүжилт авахад тулгардаг саад бэрхшээл

Гуравдугаар бүлэгт дэлхий хэмжээнд алтны бичил уурхайн салбарт албан ёсны санхүүжилт, хөрөнгө оруулалт хийхэд тулгардаг хэд хэдэн асуудлын талаарх туршлагыг өгүүлсэн. planetGOLD хөтөлбөрөөс¹⁹ холбогдох материалын судалгаа болон санхүү, хөрөнгө оруулалтын 40 гаруй мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаар дамжуулан хийсэн судалгаанд үндэслэн алтны бичил уурхайн салбартай хамтран ажиллахад хөрөнгө оруулагчдад саад учруулдаг асуудлыг тодорхойлсон. Бичил уурхайчид болон хөрөнгө оруулагчдын зүгээс хамгийн ихээр чухалчлан үздэг асуудлыг доор нэгтгэн харуулав.

4.1 Санхүүжилт авахад тулгардаг саад бэрхшээл

Алтны бичил уурхайн үйл ажиллагааны албан ёсны байдал. Алтны бичил уурхайн олонх байгууллагын хувьд албан ёсны санхүүжилт авахад тулгардаг гол асуудал нь албан бус үйл ажиллагаа, зарим тохиолдолд хууль бус үйл ажиллагаа явуулдаг оршдог байна. Албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг ихэнх зээлдүүлэгчид албан бус үйл ажиллагаанд хөрөнгө оруулах боломжгүй байдаг.

Магадлан шинжилгээний шаардлага хангах боломжгүй байх. Хөрөнгө оруулагчид санхүүжилт хийхдээ байгаль орчин, нийгэм болон засаглалд холбогдох эрсдлийн үнэлгээ хийх нь элбэг болсон. Бичил уурхайчдын байгууллагуудын хувьд санхүүжүүлэгчдийн тавьсан байгаль орчин, нийгэм болон засаглалын талаарх бүх шаардлагыг хангахад хүндрэлтэй, мөн тэд тухайн шаардлагыг хангаж ажиллаж байгаагаа хэрхэн баримтжуулахаа мэдэхгүй байх талтай. Түүнчлэн, бичил уурхайн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанаас гардаг эерэг үр нөлөөг ойлгож тодорхойлон таниулснаар нөлөөллийн хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах боломжтой гэдгийг мэдэхгүй байж болох юм.

Хэмжээ. Бичил уурхайн үйл ажиллагаа ихэнхдээ жижиг хэмжээтэй байдаг бөгөөд олборлосон бүтээгдэхүүн нь мөнгө болох хүртэл зардал өндөр гардаг нь арилжааны банк болон хувийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй байх нөхцөл болдог. Ийм төрлийн жижиг бизнест бичил санхүүжилт, олон нийтийн хуримтлал (сан), эсвэл уул уурхайг дэмжих улсын төсвийн сангаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг зэрэг арга хэмжээ байдаг боловч санхүүжилтийн хэмжээ нь бага байдгаас тухайн бичил уурхайн үйл ажиллагааг үндсээр нь өөрчилж мэргэжлийн түвшинд хүргэхүйц тоног төхөөрөмж худалдан авах дорвитой хөрөнгө оруулалт болж чаддаггүй.

Алтны бичил уурхайн үйл ажиллагааны тусгай шаардлагыг хангах хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн дутмаг байдаг. Алтны бичил уурхайн салбар өндөр эрсдэлтэй салбар гэдэг олон нийтийн ерөнхий хандлагаас шалтгаалж бичил уурхайн салбарт санхүүжилт хийх сонирхолтой хөрөнгө оруулагч цөөн байдаг. Санхүүжилт хийх сонирхолтой хөрөнгө оруулагчид ч гэсэн өндөр барьцаа хөрөнгө, өндөр хүү, зээлийн эргэн төлөлтийн хатуу хуваарь баримтлах гэх мэт хөрөнгө оруулалтаасаа ямар нэгэн эрсдэлгүйгээр ашиг олох хатуу нөхцөлтэй гэрээ хийхийг хүсдэг. Түүнчлэн, санхүүжилт авсан тохиолдолд бичил уурхайн онцлог, улирлын чанартай үйл ажиллагаа, ашигт малтмалын агуулгаас шалтгаалж гарц янз бүр байснаас бэлэн мөнгөний урсгал тогтмол бус болж, зээлийн эргэн төлөлт алдагдах эрсдэл гэх мэт бодит нөхцөл байдлыг тусгах боломжгүй байдал нь хүндрэл үүсгэдэг. Эдгээр нөхцөл нь илүү боломжтой цөөн хэдэн бичил уурхайчдаас бусдад нь хэтэрхий үнэтэй, хүнд тусдаг учир ийм санхүүжилт авах боломжгүй болдог. Түүнчлэн, зөвхөн ашгийн төлөө ажилладаг хөрөнгө оруулагчид алтны бичил уурхай шиг өндөр эрсдэлтэй салбарт оруулсан хөрөнгөө хэд дахин нугалахуйц өндөр ашиг олох зорилгоор санхүүжилт хийдэг тул ихэнх бичил уурхайн байгууллагууд ийм нөхцөлийг хүлээж авах боломжгүй байдаг байна.

19 https://www.planetgold.org/sites/default/files/2020-04/Unlocking-Finance-for-ASGM_final_0.pdf

Дэлхий нийтийн өмнөх туршлагаас харахад буруу, шаардлага хангахгүй зүйлд санхүүжилт хийснээр үр ашиг гардаггүй гэдэг нь илэрхий байна. Жишээлбэл, шаардлага хангахгүй, техник, тоног төхөөрөмж түрээслүүлэх, эсвэл орон нутгийн бичил уурхайчдын үйлдвэрлэлийн шаардлагад нийцэхгүй хүчин чадалтай төхөөрөмж бүхий баяжуулах цех байгуулах гэх мэт.

Бизнесийн туршлага, /мэдээлэл дутмаг байх.

Бичил уурхайчдын ихэнх нь албан ёсны санхүүжилтийн бүтцийг мэдэхгүй, бизнес менежментийн сургалтад хамрагдаагүйгээс хөрөнгө, санхүүгийн байгууллагатай хэрхэн харьцахаа мэддэггүй. Түүнчлэн олборлолтын газрынхаа нөөцийг мэдэхгүй, геологийн тогтоцын мэдээлэл байхгүйгээс хөрөнгө оруулагчид тэдэнтэй хамтран ажилласан тохиолдолд олж болох ашиг орлогоо тооцоолох боломжгүй байдаг.



Төрийн байгууллагын тогтвортой дэмжлэг дутмаг. Дэлхий нийтийн туршлагаас харахад дэмжлэг, тусалцааг тогтвортой хангаагүйгээс шалтгаалж алтны бичил уурхайн салбарт хэрэгжүүлсэн нилээд хэдэн санхүүжилтийн хөтөлбөр зогсож байсан. Эсрэгээрээ, ENAMI-ийн туршлагаас үзэхэд сургалт хийх, чадавх бэхжүүлэх, хөгжүүлэх болон бизнесийн үйлчилгээг тогтмол, найдвартай хүргэх нь тухайн салбарын хувьд өндөр ач холбогдолтой.

Сонголт. Эцэст нь зарим бичил уурхайчид албан ёсны санхүүжилт авахад шаардагддаг санхүүгийн болон үйл ажиллагааны олон нөхцөлийг хангах боломжгүй, эсвэл хангахыг хүсэхгүй байх тохиолдол байдаг. Тэд голдуу гэр бүлийн хүрээнд, найз нөхдөөсөө, эсвэл найдвартай, итгэл хүлээсэн орон нутгийн дундын худалдаачнаас санхүүгийн дэмжлэг авахыг илүүд үздэг. Цаашилбал, бичил уурхайчид албан бус эдийн засгийн зарчмаар ажилласнаар орлогын албан татвар, ашигт малтмал ашигласны төлбөр төлөхөөс зайлсхийх боломжийг олгодог.

4.2 Санхүүжилт олгоход тулгардаг саад бэрхшээл

Олон нийтийн хандлага ба байгаль орчин, нийгэм болон засаглалтай холбоотой эрсдэл. Олон хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгчдийн хувьд алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулахад энэ салбарын үйл ажиллагааны талаарх олон нийтийн хандлага, байгаль орчин, нийгэм болон засаглалтай холбоотой эрсдэлүүд үндсэн саад тотгор болдог. Алтны бичил уурхайн салбарын талаарх олон нийтийн сөрөг хандлага дараах асуудлуудтай холбоотой байдаг. Үүнд: хариуцлагагүй, мэргэжлийн бус үйл ажиллагаа явуулдаг, ихэвчлэн албан бус, зарим газар хууль бус үйл ажиллагаа явуулдаг, мөнгө угаах болон бусад гэмт хэрэгтэй холбоотой байдаг, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг, зарим газарт зөрчил мөргөлдөөнд холбогддог гэх мэт олон асуудал багтана. Энэ талаар хэвлэл мэдээллээр байнга мэдээлдэг бөгөөд бусад байгууллагуудын адилаар хөрөнгө оруулагч, санхүүгийн байгууллагуудын дунд ч энэ талаар сөрөг хандлагатай байдаг. Ерөнхийдөө, уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид бичил уурхайн зүгээс том уурхайн төсөлд учруулдаг эрсдэл болон зөрчил мөргөлдөөнөөс үүдэн уг салбарын талаар анх таньж мэдсэн байдаг.

Магадлан шинжилгээний шаардлагыг хангахад өртөг, зардал нь өндөр байдаг. Алтны бичил уурхайд зориулсан магадлан шинжилгээний үнэлгээний удирдамж, журам дутмаг байх, санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалтыг орон нутагт хянах механизм дутмаг байх зэрэг шалтгаанаар хөрөнгө оруулагчид магадлан шинжилгээний шаардлагыг хангах өртөг нь энэ үйл ажиллагаанаас олох ашгаас илүү байна гэж үздэг.

Алтны бичил уурхайн талаарх мэдлэг, туршлага дутмаг. Алтны бичил уурхайн үйл ажиллагаа нь албан ёсны эдийн засгийн салбар болоод удаагүй байгаа учраас хөрөнгө оруулагчид энэ салбарын хөрөнгө оруулалтын ашгийг тооцоолох туршлага, хэрэглэгдэхүүн дутмаг байдаг. Мөн доорх саад бэрхшээл байнга тулгардаг. Үүнд:

- ▶ Төслийн үнэлгээ хийж, тооцоолоход шаардлагатай алтны бичил уурхайн талаарх мэргэжил, мэдлэг дутмаг;
- ▶ Эрсдэлийг тодорхойлж, тооцоолж, зохицуулахад шаардлагатай бүртгэл, мэдээлэл дутмаг;
- ▶ Алтны бичил уурхайн байгууллага болон хөрөнгө оруулагчдын дунд зуучлагчаар ажиллах тогтвортой, албан ёсны зуучлах байгууллага дутмаг. Ялангуяа бичил уурхайн үйл ажиллагаа тарж бутарсан байдлаар явагддаг бол тэднийг зангидаж өргөжүүлэх шаардлагатай тохиолдолд зуучлагчийн үүрэг маш чухал байдаг;
- ▶ Салбарын хэмжээнд санхүүжилтийн шийдлийг өргөжүүлэх чадвар сул;
- ▶ Нөлөөллийн хөрөнгө оруулагчдын хувьд туршилтаар хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнгийн талаарх тоо баримт, мэдээлэл дутмаг байснаас энэ үйл ажиллагаанаас гарах боломжтой эерэг үр дүнг тооцоолох боломжгүй, салбарын хэмжээнд үр нөлөөний хэмжүүр дутмаг байдаг;

Хөрөнгө оруулах боломжтой төсөл байхгүй. Алтны бичил уурхайн салбарт одоогийн байдлаар хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, оролцооны арга хэлбэр, нөхцлийг тодорхой тусгасан хөрөнгө оруулж болохуйц төслийн санал, үүнийг холбогдох талуудад хүргэж үр дүнтэй зохицуулалт хийх чадвартай зуучлагч байхгүй байна. Түүнчлэн, уул уурхайн салбарт оруулдаг өндөр дүнтэй хөрөнгө оруулалт одоохондоо бичил уурхайн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагаас хэтэрсэн, эсвэл дундын худалдаачдын зохицуулах чадвараас хэтэрсэн байж болно. Зарим тохиолдолд алтны бичил уурхайн үйл ажиллагаа ирээдүйн хөрөнгө оруулагчдын шаардлагад аль ч талаараа нийцэхгүй байх талтай. Хөрөнгө оруулагчид алтанд хөрөнгө оруулах талаар мэдлэгтэй боловч бичил уурхайн үйл ажиллагааг тэдний шаардлагад нийцэхгүй гэж үздэг нь энэ салбарын талаар мэдлэг мэдээлэл, туршлага дутмаг байдагтай холбоотой.

Журам, стандарт болон зааварчилгаа нь алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийхэд зарим тохиолдолд саад болох талтай. Тэдгээр саад бэрхшээл нь тухайн улсын нөхцөл байдал болон санхүүжилтийн хэлбэрээс шалтгаалдаг. Жишээлбэл,

- ▶ Тухайн улсын гадаадын хөрөнгө оруулалт болон өмчлөлийн тухай хууль, дүрэм журам, гадаадын шууд хөрөнгө оруулалт, татварын тухай бодлого, зохицуулалтын орчин тогтворгүй байх нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд саад бэрхшээл үүсгэдэг. Түүнчлэн хуулиар хүлээсэн үүрэг болон ёс зүйн хариуцлагыг хязгаарлалт, хориг хэлбэрээр ашиглах нь хөрөнгө оруулагчийн хувьд саад болох магадлалтай.²⁰ Эцэст нь, зарим хөрөнгө оруулагчид Конго Улс гэх мэт санхүүгийн шилжүүлэг хийхэд хязгаар тавьдаг тодорхой зарим нутаг дэвсгэрт үйл ажиллагаа ч явуулах боломжгүй байдаг. Мөн зөвшөөрөлгүй бүс нутгийн жагсаалтад байдаг улс орнуудад хөрөнгө оруулалт хийдэггүй.

- ▶ Орон нутгийн банкуудын зээлийн хүүгийн тааз бага байдаг нь алтны бичил уурхайн эрсдэлээс хамгаалах боломжгүй байх талтай.

²⁰ Дэлхийн нөлөөллийн хөрөнгө оруулалтын сүлжээ (GIIN). (2019). Нөлөөллийн хөрөнгө оруулагчдын ээлжит судалгаа. Дараах цахим хуудаснаас үзнэ үү: https://thegiin.org/assets/GIIN_2019%20Annual%20Impact%20Investor%20Survey_webfile.pdf

► Тайлан тавих тухай дүрэм журам дутмаг, зарим тохиолдолд огт байхгүй байдаг нь бүх төрлийн санхүүжилт татахад саад тотгор болдог. Учир нь бүх төрлийн санхүүжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа нь тайлан тооцоон дээр үндэслэн явагддаг. Жишээлбэл, нөлөөллийн хөрөнгө оруулалтын журам байхгүйгээс ийм төрлийн санхүүжилтийг хязгаарлах магадлалтай. Аливаа санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд дүрэм, журам, стандартын шаардлагыг хангахад их хэмжээний магадлан шинжилгээ, хяналт шалгалт шаардлагатай бөгөөд алтны бичил уурхайн салбарт энэ үйл ажиллагаа өндөр өртгөөр хийгддэг.

Эдгээр саад бэрхшээлээс шалтгаалж эрсдэл өндөртэй төслийг санхүүжүүлэх зоригтой хөрөнгө оруулагчид ч алтны бичил уурхайн салбарт ажиллахаас зайлсхийдэг нь бичил уурхайн салбар нь эрсдэлийг даван туулж ашиг шим хүртэх талаар газар тариалан гэх мэт эдийн засгийн бусад тогтворжсон салбаруудтай өрсөлдөх хэмжээнд хүрээгүйтэй холбоотой. Алтны бичил уурхайг эрсдэл өндөртэй салбар гэх хандлага нийтлэг учир төрийн болон сайн үйлсийн хөрөнгө оруулалт энэхүү салбарт чухал хэрэгтэй байсаар байна. Ингэснээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад тулгарах эрсдэлийг зохих хэмжээгээр сааруулж алтны бичил уурхайн салбарын талаарх сөрөг хандлага буурах, сайн туршлага хуримтлуулах бөгөөд үүнийг салбарын хэмжээнд баримтжуулснаар дараа дараагийн хөрөнгө оруулагчдыг татах, тэдний шаардлагыг хангах нөхцөл бүрдэж эхэлнэ. Сайн туршлага хуримтлуулан, үйл ажиллагаагаа албан журмаар явуулснаар тус салбар бүхэлдээ албажих эхлэл болно. Бичил уурхайчдыг тогтмол мэргэшүүлж, санхүүгийн мэдлэг чадвартай болгох нь зээл, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн сайн туршлага хуримтлуулахад хувь нэмэр оруулна.

5. Алтны бичил уурхайн албан ёсны санхүүжилтийг нэмэгдүүлэх нь

Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд албан ёсны санхүүжилт татахад тулгардаг саад бэрхшээлийг анхааралдаа аван санхүүжилт хийх аргыг загварчлахад бичил уурхайг дэмжихийн хажуугаар хөрөнгө оруулагчдын санааг зовоож байгаа эрсдэлийг сааруулах боломжтойгоор хийх нь хамгийн чухал. Энэ бүлэгт бичил уурхайн салбарт бий болсон туршлага болон хөрөнгө оруулахад тулгардаг бэрхшээл зэргийг анхааран төр, донор байгууллагууд болон бусад сонирхсон талуудын хөрөнгө оруулалтыг татан, бичил уурхайн албан ёсны санхүүжилтийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлохыг зорьсон. Энэ бүлгийн төгсгөлд эдгээр зөвлөмжийг нэгтгэн дүгнэж хүснэгт хэлбэрээр харуулсан болно.

5.1 Алтны бичил уурхайн салбар болон санхүүжилтийн талбар

Алтны бичил уурхайн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх талаарх өмнөх туршлагаас үзэхэд зорилтот бүлэг болон орон нутгийн ашигт малтмалын зах зээлийн талаар цогц мэдлэгтэй болох нь чухал гэдгийг тэмдэглэсэн. Аливаа үйл ажиллагааг эхлэхийн өмнө бичил уурхайчдын талаар маш тодорхой ойлголттой болох хэрэгтэй. Түүнчлэн санхүүжилтийн болон зээлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлно. Ингэхдээ дараах мэдээллийг цуглуулна:

► **Зорилтот бүс нутгийн хүн ам зүйн бүтцийн тоо баримт.** Бичил уурхайчдын боловсрол, туршлага, яс үндэс, насны бүлэг, уурхайн ажил хийх сонирхол/хөшүүрэг болон алтны гарц/хэмжээний талаар тоон болон чанарын судалгаа хийж тоо баримт цуглуулна. Бичил уурхайчдын ашигладаг тоног төхөөрөмж, үүнийг ашиглах, тордох чадвар гэх мэт өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг нарийн ойлгож мэдэх шаардлагатай. Ингэснээр зээл, түрээс болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тэдний хэрэгцээ шаардлагад тохируулан, зөв загварчилж шаардлагатай дэмжлэгийг нь үзүүлэх боломжтой болно.

► **Геологийн бүтцийн мэдээлэл.** Тухайн газар орны геологийн бүтцийн талаарх мэдлэгтэй байх нь бичил уурхайгаар олборлолт хийх боломжтой газрын нөөцийг тодорхойлох, хил хязгаарыг

нь тогтооход чухал ач холбогдолтой. Мөн энэ нь тухайн олборлолтын газрын ашигт малтмалын агуулгыг тооцоолж санхүүжилтийн хүсэлт гаргах үндэслэл болох бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн мэдээлэл болно.

► **Алтны зах зээл ба нийлүүлэлтийн сүлжээний талаарх мэдээлэл.** Алтны бичил уурхайн зах зээл бүр өөр байдаг. Алтны бичил уурхайн үйлдвэрлэлийг албан ёсоор санхүүжүүлэх стратеги боловсруулахад орон нутгийн алтны зах зээлийн үйл явц болон түүний ашиг орлогын бүтцийг маш сайн ойлгох хэрэгтэй. Үүнд алтыг хэрхэн худалдан авдаг, хэрхэн худалддаг, алтны үнэ ханшид нөлөөлөх хүчин зүйл, алтны худалдаачдын сүлжээ, орлогын албан татвар болон роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны татварын хэмжээ, шаардлага, ялангуяа алтыг хууль бусаар хил давуулан худалдаалж байж болзошгүй хөрш орны ижил төстэй зах зээлийн нөхцөлтэй харьцуулах зэрэг судалгаа багтана.

5.2 Бодлогын таатай орчин бүрдүүлэх

Төр болон донор байгууллагууд алтны бичил уурхайн санхүүжилтийг зохицуулах зорилгоор бодлогын таатай орчин бүрдүүлэх чиглэлд эрчимтэй хамтран ажиллах шаардлагатай. Үүнд дараах асуудлууд багтана:

► **Албажуулалтыг эрчимжүүлэх.** Эдгээр бүх зөвлөмжийн гол түлхүүр нь Засгийн газар алтны бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах чиглэлээр эрчимтэй ажиллаж, салбарын үйл ажиллагааг сайжруулах арга замыг тасралтгүй эрж хайхад оршдог. Хуулийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, албан ёсны үйл ажиллагаа эрхэлдэг болох нь бичил уурхайд албан ёсны санхүүжилт авч ирэх гол хурдасгагч хүч юм. Зөвхөн үйл ажиллагааг нь албажуулснаар албан ёсны санхүүжилт татахад тулгарч байгаа бүх асуудлыг шийдвэрлэж чадахгүй ч, бичил уурхайг албан ёсны үйл ажиллагаа гэж хүлээн зөвшөөрөх нь тогтвортой байдал болон амжилттай бизнесийн гол үндэс болсон зохистой бүтэц, зохион байгуулалтыг бий болгодог. Албан ёсны статус нь хөрөнгө оруулагчдад итгэл найдвар төрүүлдэг. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс улс орнуудад зориулж гаргасан Үндэсний хөтөлбөр боловсруулах зөвлөмжид бичил уурхайн үйл ажиллагааг хэрхэн албажуулах талаар тодорхой тусгасан.²¹



21 НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, 2017. Зөвлөмж: Алтны бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээг бууруулах, боломжтой нөхцөлд халах тухай Үндэсний хөтөлбөр боловсруулах. НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр, Женев хот.

Бичил уурхайн байгууллага байгуулан, нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтанд ороход нь дэмжлэг үзүүлэх, алтны бичил уурхай эрхлэх зөвшөөрөл олгох ил тод, ойлгомжтой, тодорхой тогтолцоо бүрдүүлэх болон бичил уурхайн байгууллагууд нь хуулийн дагуу ажиллаж байгаа сайн туршлагыг олон нийтэд түгээх гэх мэт арга хэмжээ авч болно.

► **Техникийн дэмжлэгийг тогтвортой үзүүлэх.** Алтны бичил уурхайн салбарын нийгэм, байгаль орчны хариуцлагатай байдлыг дэмжих, алтны үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулж, дадлагажуулах.

► **Бичил уурхайчдад зориулж алтны нөөцийн талаарх геологийн мэдээлэл болон энгийн тооцооллыг хийж өгөх.** Ингэснээр санхүүжилтийн хүсэлт гаргахад тухайн газраас ямар ашиг олох тооцооллыг хавсаргах боломжтой.

► **Орон нутгийн санхүүжүүлэгч байгууллагуудын талаар судалгаа хийх.** Энэ судалгааг хийснээр алтны бичил уурхайн үйл ажиллагаатай холбож болохуйц жижиг, дунд бизнесийн бүтээгдэхүүнийг тодорхойлж болно. Түүнчлэн орон нутгийн түвшинд санхүүжилт хийхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох боломжтой болно.

► **Санхүүжилтээс гадна бусад нэмэлт дэмжлэг болон олон төрлийн үйлчилгээг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх.** Чили Улсын ENAMI байгууллагын туршлагаар санхүүжилт олгохоос гадна олон төрлийн үйлчилгээг давхар үзүүлснээр удаан хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.

► **Харилцаа холбоо үүсгэх ажлыг дэмжих.** Алтны бичил уурхайн талаарх олон нийтийн дундах сөрөг хандлагыг бууруулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр бичил уурхайн үйл ажиллагаанд бий болсон сайн туршлагыг түлхүү сурталчлах, ингэснээр мөн эрсдэлийн талаарх хөрөнгө оруулагчдын үзэл бодлыг өөрчлөх боломжтой.

► **Алтны татвараас санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх.** Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг тогтмол үзүүлэх зорилгоор бичил уурхайчдын үйлдвэрлэсэн алтанд тодорхой хэмжээгээр татвар ноогдуулах эсвэл алт худалдсан орлогоос сан бүрдүүлэх боломжтой юм. Үүний жишээгээр Гана Улсын нөхөн сэргээлтийн санг дурдаж болно. Энэ сан нь улсад тушааж байгаа бичил уурхайгаар олборлосон алтны орлогын 1 хувийг бичил уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газар нутгийг нөхөн сэргээхэд ашиглах зарчмаар ажилладаг байна.

► **Хууль, дүрэм, журмыг сайжруулах.** Гадаадын хөрөнгө оруулалт, нөлөөллийн хөрөнгө оруулалтын тухай болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, тогтоолыг судалж алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг тусгаж сайжруулах шаардлагатай.

► **Экспортын итгэмжлэгдсэн байгууллагуудаар дамжуулж хөтөлбөр хэрэгжүүлэх.** Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хэрэглэгддэг техник (жишээлбэл, экскаватор) тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид гэх мэт алтны бичил уурхайн салбарт бизнес хийх сонирхолтой байгууллагуудад Засгийн газрын зээл олгох, баталгаа гаргах, даатгал хийх зэргээр хамтарч ажиллан бичил уурхайн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь чухал юм.

5.3 Бичил уурхайчдын шаардлагад санхүүжилтийн эх үүсвэрийг нийцүүлэх нь

Санхүүжилт, хөрөнгө оруулалтад алтны бичил уурхайн бизнесийн хэрэгцээ шаардлага болон санхүүжүүлэгчийн зорилго хоёрыг нийцүүлэх шаардлагатай байдаг. Хоёр талын хэтийн төлөвийг анхаарч үзсэнээр бичил уурхайчдын хэрэгцээ шаардлага, чадамжид яг таарсан санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох нь хамтын ажиллагааг амжилтад хүргэх боломжийг нэмэгдүүлдэг.



Гэрэл зургийг Хуан Мануель Чаварриа

Алтны бичил уурхайн хэрэгцээ, шаардлага

Алтны бичил уурхайчид ихэвчлэн олборлолт, баяжуулалт болон эдгээр ажилд ашигладаг цахилгаан үүсгүүр буюу генератор гэх мэт тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилт эрж хайдаг. Мөн түүнчлэн амжилттай, хариуцлагатай ажиллаж байгаа бичил уурхайчдын хувьд геологийн судалгаа, хайгуул хийх, нийгэм, байгаль орчны үнэлгээ хийх, бизнесийн төлөвлөгөө гаргах болон бусад холбогдох бизнес хөгжлийн асуудалд хөрөнгө оруулалт хэрэгтэй болдог. Хэдий тийм ч алтны бичил уурхайн салбар нь ил болон далд уурхай, шороон ордод ажилладаг ганц нэг хүнээс эхлээд мянга мянгаараа нэгдэн маш өргөн хүрээнд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг, олон оролцогч талуудаас бүрддэг. Энэ ажлыг хоршоолол хэлбэрээр хамтран, эсвэл хувь хүн эзэмшиж хийж болно. Алтны бичил уурхайн үйлдвэрлэл нь тухайн бичил уурхайчдын техникийн болон санхүүгийн мэдлэг, чадвар, байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдэх чадвар болон технологийн үр ашигтай хэрэглээ зэргээс хамаарч ялгаатай байдаг. Иймээс эдгээр бүх нөхцөл байдалд таарсан санхүүжилтийн эх үүсвэр байдаггүй билээ. Жишээлбэл, бичил уурхайчин, эсвэл бичил уурхайн үйл ажиллагаанд зөвхөн 10,000 ам.долларын зээл авч уурхайн гүний усыг зайлуулах төхөөрөмж авснаар үйл

ажиллагаагаа хэвийн явуулах боломжтой байж болох бол хэд хэдэн бичил уурхайн байгууллагын үйлчлүүлдэг хүдэр баяжуулах цехэд тоног төхөөрөмж худалдан авахад 1.5 сая ам.доллар хэрэгтэй болж ч болох юм. Түүнчлэн хэд хэдэн бичил уурхайн байгууллагын хамтран ажилладаг газарт дэд бүтэц хөгжүүлэхэд илүү их хөрөнгө оруулалт хэрэгтэй байж болох ба энэ нь тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бүтээмжийг илүү нэмэгдүүлэх магадлалтай юм.

Санхүүжилтийн зохицуулалтыг тухайн бизнест харьцангуй богино хугацаанд бодит үр дүн гаргахыг зорьж хийнэ. Хэт өндөр өр зээл, эсвэл хэтэрхий их ногдол ашиг хөрөнгө оруулагчид төлснөөс болж бичил уурхайн байгууллагууд тухайн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг хэрэгтэй зүйлдээ зарцуулж, хүссэн хэмжээний ашиг орлого олж үр дүнд хүрч чадалгүй урам хугарах, итгэл алдах тохиолдол гардаг. Цаашилбал, зарим зээлийн бүтээгдэхүүн зээлдэгчийн хэрэгцээ шаардлагыг илүү хангасан нөхцөлтэй байдаг. Жишээлбэл, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөтгөж байгаа тохиолдолд зээл, түрээсийн бүтээгдэхүүн илүү тохиромжтой байдаг бол шинэ бизнес эхлүүлж байгаа тохиолдолд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн илүү тохиромжтой байдаг. Гэсэн хэдий ч санхүүжилтийн бүтээгдэхүүний сонголт нь олон хүчин зүйлээс хамаарна.

Алтны бичил уурхайн хэрэгцээ шаардлагыг тохиромжтой хөрөнгө оруулагчидтай холбох нь

Алтны бичил уурхайн хэрэгцээ шаардлагыг хангахуйц санхүү, хөрөнгө оруулагчдыг тодорхойлоход тухайн хөрөнгө оруулагчийн санхүүгийн зорилгыг анхаарч үзэхээс гадна тэдний нийгэм, байгаль орчны зорилго, зорилтыг анхаарч үзэх шаардлагатай. Хүснэгт 1-д алтны бичил уурхайн ялгаатай хэрэгцээ шаардлагыг хангахуйц санхүүжилтийн эх үүсвэрүүдийн санхүүгийн болон бусад зорилгыг нэгтгэн харуулав. Санхүүжилтийн хэлбэрийн талаарх нэмэлт мэдээллийг үргэлжлүүлэн хүргэж байна.

Санхүүжилтийн эх үүсвэр	Бичил санхүүжилт, орон нутгийн түвшний хуримтлал	Арилжааны банкууд	Үндэсний хөгжлийн банкууд	Алт худалдан авагчдын хийсэн урьдчилсан санхүүжилт	Хувийн (хөрөнгө оруулалт, зээл, хамтран хөрөнгө оруулах) болон нөлөөллийн хөрөнгө оруулалт
Санхүүжилтийн зорилго	Хөрөнгөө хэвээр нь авч үлдэх, зах зээлийн жишгээс доогуур, бага боловч боломжийн ашиг	Боломжийн хэмжээний ашиг	Зах зээлийн жишгээс доогуур, бага хэмжээний ашиг орлого	Хөрөнгөө хэвээр нь авч үлдэх, боломжийн нөхцөлтэй буцаан төлөлтийн систем	Хөрөнгөө хэвээр нь авч үлдэх (“нөлөө гаргах нь чухал”) болон боломжийн хэмжээний ашиг орлого (“санхүүжилт, ашиг олох нь чухал”)
Бусад зорилго	Хүн амын амьжиргааг дээшлүүлэх болон ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх; жендэрийн тэгш байдлыг хангах	Жижиг бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиг үүрэгтэй бөгөөд зах зээлийн жишгээс доогуур бага хэмжээтэй ашиг олох	Холимог санхүүжилттэй арилжааны хөрөнгийг нэмэгдүүлэх Тухайн улсын эдийн засгийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах	Хариуцлагатай эх үүсвэрээс алт худалдан авах	Нөлөөллийн хөрөнгө оруулагчдын хувьд хийсэн санхүүжилтээс нь бодит, хэмжигдэхүйц нийгмийн эерэг нөлөө гарсан байх
Дэмжлэг авсан алтны бичил уурхайн хэмжээ	500-10,000 ам.доллар (Гар аргаар ашигт малтмал олборлох)				
	10,000 – 50,000 ам.доллар (Хувиараа ашигт малтмал олборлох)				
		50,000 - 500,000 ам.доллар (Бичил уурхайн байгууллага, хамт олон)			
	500,000 - 5 сая ам.доллар (дунд хэмжээний үйлдвэрлэл болон бичил уурхайн хэд хэдэн байгууллага нэг газар ажилладаг)				
	5 - 10 сая ам.доллар (хүдэр баяжуулах төвлөрсөн цех гэх мэт томоохон үйл ажиллагаа)				
←Донор/сайн үйлсийн санхүүжилт→ Холимог санхүүжилт хийх замаар бусад төрлийн санхүүжилтийг дэмжиж болно; Алтны бичил уурхайн салбарт техникийн тусламж үзүүлэх замаар дэмжих;					

Зээлийн санхүүжилт

► **Бичил санхүүжилт.** Бичил санхүүжилт авахад ердийн арилжааны банкнаас зээл авахтай адил их хэмжээний шаардлага тавьдаггүй учраас санхүүгийн хязгаарлагдмал боломжтой жижиг бизнесийн үйл ажиллагаанд илүү тохиромжтой байдаг. Гэсэн хэдий ч бичил санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулах боломж нь ихэнхдээ хязгаарлагдмал байдгаас албан ёсны санхүүжүүлэгч, хөрөнгө оруулагчид, төр засаг болон алтны худалдаачдын зүгээс тавьсан байгаль орчин, нийгмийн шаардлагыг хангаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, сайжруулахад шаардлагатай хөрөнгийг гаргах боломжгүй байж болох юм.

► **Орон нутгийн хуримтлал болон зээлийн багцууд.** Орон нутгийн зүгээс хуримтлалын болон зээлийн сангийн менежмент, хяналт-шинжилгээг хариуцсанаар уг сангаас алтны бичил уурхайчдын хэрэгцээ шаардлага, хүчин чадалд нийцсэн санхүүжилт хийх, зээлийн нөхцөлийг орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан хийхийг баталгаажуулах ач холбогдолтой. Эдгээр багцуудад нутгийн иргэдийг санхүү, бизнесийн ур чадварт сургах сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг тусгасан байдаг. Ийм орон нутгийн сангийн хөрөнгийн хэмжээ тийм ч их байдаггүй бөгөөд жижиг бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд илүү тохиромжтой.

► **Арилжааны банкууд.** Банкууд нь зээл олгох уламжлалын дагуу зээлдэгчээс барьцаа хөрөнгө шаарддаг. Түүнчлэн алтны бичил уурхайн салбар нь санхүүжилт хийхэд өндөр эрсдэлтэй салбар гэж тооцогддог учраас банкны зүгээс илүү өндөр хүү, эсвэл зээлийн эргэн төлөлтийн хугацааг маш богино байхаар тохируулах магадлалтай. Энэ нь зээлийн зөөлөн нөхцөл, холимог хөрөнгө оруулалт шаардлагатай бичил уурхайчдын хувьд хүндрэлтэй байдаг. Нөгөөтээгүүр, хоршооны банкууд (хадгаламж, зээлийн хоршоо) жижиг дунд бизнест санхүүжилт хийх чиг үүрэгтэй учир хувийн арилжааны банкуудтай харьцуулбал арай зөөлөн нөхцөлтэй байж болох юм.

► **Үндэсний хөгжлийн банкууд.** Үндэсний хөгжлийн банкууд нь төрөл бүрийн чиг үүрэг, зах зээлийн арга барил бүхий байгууллагууд байдаг учраас тэдний хөгжлийн чиг үүрэг нь эдгээр банкуудыг тогтвортой, шинийг эрэлхийлсэн илүү удаан хугацааны динамик өсөлт, хөгжлийг дэмжих жижиг бизнесийн чиглэлийн хөрөнгө оруулалтад төвлөрч ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Иймээс Үндэсний хөгжлийн банкууд нь бага үнийн дүнтэй хөрөнгө оруулалт хийж арилжааны банкуудыг зээл олгохыг дэмжих замаар алтны бичил уурхайн салбарын өсөлт, хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломжтой юм. Мөн түүнчлэн шаардлагатай тохиолдолд санхүүжилтээс гадна техникийн дэмжлэг тусалцаа үзүүлж болно.

Хөрөнгө оруулалт

► **Хувийн хөрөнгө оруулагчид.** Алтны бичил уурхайн бизнес эрхлэгчдийн хувьд хувийн хөрөнгө оруулагчидтай (жишээлбэл, хөгжиж байгаа эдийн засгийн салбарт эртнээс хөрөнгө оруулж ашиг шим хүртэхийг хүсдэг, эсвэл “хариуцлагатай” хөрөнгө оруулах замаар ашиг орлого олохыг хүсдэг хөрөнгө оруулагчид гэх мэт) хамтран ажиллах нь санхүүжилтийн сайн эх үүсвэр байж болох юм. Хамтын ажиллагааны хэлбэр нь хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, эсвэл бусад төрлийн хөрөнгө оруулалт байж болно. Нөгөөтээгүүр хувийн хөрөнгө оруулалт нь маш хатуу магадлан итгэмжлэх процесстой байдаг бөгөөд шинэ, эсвэл тогтворжиж хөлөө олоогүй бизнесийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтаасаа хэд дахин их ашиг орлого олох шаардлага тавих магадлалтай юм. Иймээс алтны бичил уурхайн салбар том хэмжээний хувийн хөрөнгө оруулагчдын анхаарлыг бараг л татдаггүй.

► **Нөлөөллийн хөрөнгө оруулагчид.** Нөлөөллийн хөрөнгө оруулагчид нь нэр хүндийн болон санхүүгийн холбогдолтой эрсдэлтэй нөхцөлд ихэвчлэн оролцохыг хүсдэггүй. Иймээс тэд алтны бичил уурхай гэх мэт шинэ салбарт тухайн үйл ажиллагаанаас үр дүн гарах боломжтой гэдэг нь тодорхой байсан ч тэр болгон хөрөнгө оруулалт хийдэггүй. Маш олон нөлөөллийн

Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд банкууд хөрөнгө оруулах тухай харгалзан үзсэн ч гэсэн энэ салбарын хувьд албан ёсны санхүүжилт авах боломж хаагдмал байх талтай. Алтны бичил уурхайчид ихээр гадуурхагддаг учир банкнаас үйлчилгээ авдаггүй. Албан ёсны санхүүжилтийн үйлчилгээ байсан ч гэсэн хэрхэн энэ үйлчилгээг авах, ашиглах талаар мэдэхгүй байх тохиолдол элбэг. Иймээс орон нутгийн энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч байгууллага, эсвэл гуравдагч этгээд бичил уурхайчдын байгууллагатай хамтран ажиллаж тэдний санхүү бизнесийн мэдлэг, чадвар зохих хэмжээнд хүртэл хүсэл сонирхлыг нь төлөөлөх, туслах шаардлагатай юм.

хөрөнгө оруулагчид уул уурхайн үйл ажиллагаанд тийм ч таатай ханддаггүй бөгөөд бичил уурхайн үйл ажиллагааны талаар болон үүнээс гарч болох хөгжлийн боломжийн талаар мэдлэг, мэдээлэл дутмагаас бичил уурхайн салбарыг байгаль орчны бохирдол болон нийгмийн сөрөг нөлөөллийн эх үүсвэр гэж үздэг. Гэсэн хэдий ч алтны бичил уурхай шиг өндөр эрсдэлтэй боловч их хэмжээгээр эерэг нөлөө гаргаж болохуйц төслүүд илүү эрсдэл даах чадвартай, хүсэлтэй нөлөөллийн хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах талаар илүү ажиллах шаардлагатай. Ийм нөлөөллийн хөрөнгө оруулагчдын тоонд өндөр орлоготой хувь хүмүүс болон гэр бүлийн бизнес эрхлэгчид ордог. Тэдний хөрөнгө оруулах сонирхол нь уян хатан байдаг бөгөөд ямар нэгэн бизнесийн эхний үе шат, эсвэл ашиг орлого олох нь тодорхойгүй үйл ажиллагааг дэмжих бага хэмжээний хөрөнгө оруулалт хийх гэх мэт боломж бололцоотой байдаг. Түүнчлэн хөрөнгө оруулалтын тайлагналын шаардлага нь том хэмжээний хөрөнгө оруулагчидтай харьцуулбал харьцангуй бага байдаг. Нөлөөллийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсээр байна. 2015 онд 77.4 тэрбум ам.долларын нөлөөллийн хөрөнгө оруулалт хийсэн тухай тайлан гарсан бол 2025 оны эцэс гэхэд энэ дүн 2 их наяд ам.долларт хүрнэ гэсэн таамаг гарчээ.²² Ийм их хэмжээний хөрөнгө байгаа боловч оруулсан хөрөнгийн хэмжээ санхүүжүүлэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан хөрөнгө оруулж болохуйц төслийн (санхүүгийн болон нөлөөллийн зорилтот үр дүнд хүрэхүйц төсөл) тооноос хамаарч боломж хязгаарлагдмал байна.²³ Цаашилбал, тохиролцооны дундаж хэмжээ нь зарим алтны бичил уурхайн төслийн хэрэгцээ шаардлага болон хүчин чадлаас давах тохиолдол байдаг тул жижиг хэмжээний хэд хэдэн бичил уурхайн төслийг нэгтгэн зохицуулах зуучлагч, эсвэл нийгэмд ээлтэй байгууллага, брокерийн үйлчилгээ шаардлагатай болдог.

Санхүүжилтийн бусад боломжит эх үүсвэрүүд

► **Алтны том уурхайн компаниуд.** Алтны том уурхайн компаниуд бусад жижиг хэмжээний алтны уурхайн компаниуд болон хайгуулын төслүүдэд хөрөнгө оруулах нь элбэг тохиолддог. Түүнчлэн том уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын санаачилгын хүрээнд орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө оруулалт хийдэг. Том уурхайн компаниуд хамтарсан үйлдвэрлэл явуулах, олборлолтын тусгай зөвшөөрөлтэй газартаа үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх зэргээр алтны бичил уурхайн үйл ажиллагаанд шууд хөрөнгө оруулалт хийх нь улам нэмэгдэж байна. Үүнээс гадна уул уурхайн компаниуд бичил уурхайгаар ашиглаж болох орд илэрцийн талаарх геологийн мэдээлэл олж авахад нь бичил уурхайчдад туслах, олборлолтын үйл ажиллагаа, арга технологио сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулах зэргээр дэмжлэг үзүүлж ажилладаг.

► **Нийлүүлэлтийн сүлжээний эцсийн оролцогчид (алт цэвэршүүлэгчид, худалдан авагчид).** Нийлүүлэлтийн сүлжээний төгсгөлд байх алтны худалдан авагчид нь бичил уурхайн үйл ажиллагааны уламжлалт хөрөнгө оруулагчид биш боловч зарим тохиолдолд тухайн уурхайгаас олборлосон алтыг хөнгөлөлттэй үнээр худалдан авах нөхцөлтэйгөөр олборлолтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгийг урьдчилан гаргах тохиролцоо хийдэг байна. Сүүлийн үед нийлүүлэлтийн сүлжээний дунд болон эцсийн шатны оролцогчид болох алт цэвэршүүлэгчид, тэдний үйлчлүүлэгчид болох алт худалдан авдаг том, жижиг компаниудын (олон улсын электроникийн болон санхүүгийн компаниуд, үнэт эдлэл үйлдвэрлэгчид гэх мэт) зүгээс алтны гарал үүсэлд илүү их анхаарал хандуулдаг болсон. Зарим нь алтны бичил уурхайн байгууллагатай эхнээс нь зөвшилцөж, худалдан авч байгаа алтныхаа гарал үүслийг тодорхой байлгахад шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг урьдчилан гаргаж хамтран ажилладаг. Алтны салбарын хувьд алт худалдан авагчид нь бусад ашгийн төлөө хөрөнгө оруулагчдаас өөр сонирхолтой байдаг. Алт худалдан авагчид Лондонгийн үнэт металлын бирж, ЭЗХАХБ-ын магадлан шинжилгээний удирдамж, болон үйлдвэрлэгчид, худалдан авагчдын улам өсөж байгаа шаардлагад үргэлж анхаарал хандуулж ажилладаг. Тэдний зүгээс зөвхөн баталгаатай хөрөнгө оруулах замаар хариуцлагатай олборлосон алт худалдан авах, нийлүүлэлтийн

22 Мартин Р. ба Лохин Р. (2017). Нөлөөллийн хөрөнгө оруулалт: Санхүүгийн болон нийгмийн санаачилгын туршлагыг мөшгих нь. Ротман менежмент. Дараах цахим хуудаснаас үзнэ үү: https://issuu.com/rotmanmag/docs/winter_17/67

23 Филиппс С.Д. ба Жонсон Б. (2019). Нөлөөлөх хүсэл: Нийгмийн нөлөөний хэрэгцээ шаардлагын тал. <https://link.springer.com/article/10.1007/s10551-019-04241-5>

сүлжээний эхэн хэсгийн оролцогчид болох бичил уурхайчдын байгаль орчин, нийгэм болон засаглалын хариуцлагатай ажиллагааг дэмжих, нөлөөлөх зорилгоор алтны бичил уурхайн үйл ажиллагааг санхүүжүүлэх хүсэлтэй байдаг. Тэд заримдаа шилжилтийн явцад гарсан зардлыг эргүүлэн төлөх, эсвэл нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулсан ажлыг санхүүжүүлэх зэрэг шаардлагуудыг тавьдаг.

Тэдгээр алт худалдан авагчид бол хөрөнгө оруулагчид биш юм. Тэдний хувьд худалдан авч байгаа алтны хариуцлагатай эх үүсвэрийг баталгаажуулах нь зарцуулсан хөрөнгөөсөө ашиг олохоос илүү чухал байдаг. Иймээс тэднийг алтны бичил уурхайн үйл ажиллагаанд урт хугацаанд шууд хөрөнгө оруулагч гэж тооцдоггүй бөгөөд харин дунд болон богино хугацааны хөрөнгө оруулагч гэж үздэг. Бусад төрлийн хөрөнгө оруулагчид байхгүй тохиолдолд алт худалдан авагчид бичил уурхайн үйл ажиллагааг бэхжүүлэх талаар дэмжлэг үзүүлж хөрөнгө оруулах боломжтой салбар гэж үздэг юм.

Донор болон сайн үйлсийн санхүүжилтийн эх үүсвэр

► Сайн үйлсийн, эсвэл донорын санхүүжилтийг алтны бичил уурхайн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсээр ирсэн итгэлцлийн сан, хандив болон донор байгууллагуудаар дамжуулан хийдэг. Эдгээр байгууллагууд тухайн орны төр засаг, ТББ-аар дамжуулан бичил уурхайчдад техникийн дэмжлэг үзүүлэх, тэдэнд чиглэсэн төрийн сан бүрдүүлэх гэх мэт санхүүжилтийн механизм бүрдүүлэх болон хувийн хэвшлийн санхүүжилтийг дэмжих зорилготой хамтарсан хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Ийм төрлийн санхүүжилтийг жендэрийн тэгш оролцоог хангах, хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх болон байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд төвлөрч хийдэг. Түүнчлэн ийм төрлийн



Гэрэл зургийг НҮБАҮХБ

санхүүжилтийг хууль, дүрэм, журам, стратегийн хэрэгжилт, сайн технологи нэвтрүүлэх, бичил уурхайчдыг ур чадваржуулах, алтны бичил уурхайн албан ёсны үйл ажиллагааны загвар төсөл хэрэгжүүлэх гэх мэт энэ салбарыг эдийн засгийн чухал салбар болгон хөгжүүлэхэд түлхэц болох үйл ажиллагаанд ашигладаг. Донор болон сайн үйлсийн санхүүжүүлэгчид ерөнхийдөө тэдний оруулсан хөрөнгө оруулалт нь эргэж төлөгдөнө гэж хүлээдэггүй. Гэсэн хэдий ч зарим сайн үйлсийн санхүүжүүлэгчид хөтөлбөрт суурилсан хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд ингэснээр тэд өмнөө тавьсан хөтөлбөрийн стратеги бодлогоо хэрэгжүүлдэг. Тэд оруулсан үндсэн хөрөнгөө бага зэргийн хүүтэй, эсвэл хүүгүй дүнгээр эргүүлэн авах хүлээлттэй байж болно. Сайн үйлсийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хувьд ашиг орлого үргэлж хоёрдугаарт байдаг.

5.4 Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд тохирсон санхүүжилтийн механизм бүрдүүлэх

Аливаа улсын засгийн газар донор байгууллагууд гэх мэт алтны бичил уурхайн үйл ажиллагааг санхүүжүүлэх механизм (ялангуяа зээлийн механизм) бүрдүүлэх чиглэлээр ажилладаг талууд дараах хэдэн алхамыг анхаарч ажилласнаар хийсэн ажил нь үр дүнд хүрэх магадлал нэмэгдэнэ. Үүнд:

► **Өөрийн улсын санхүүгийн үйлчилгээг судлах.** Ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээг илүү судлах шаардлагатай. Банкууд болон орон нутгийн хөрөнгө оруулагч

байгууллагуудад зээл олгоход тулгардаг бодит бэрхшээлийг тодорхой мэдэх нь чухал ба ингэснээр холимог санхүүжилт гэх мэт зээлийн бүтээгдэхүүн гаргахад тэдгээр саад бэрхшээлийг тооцоолж хэрхэн зохицуулахыг эхнээс нь тодорхойлох боломжтой болно. Алтны бичил уурхайд оруулсан ямар ч санхүүжилтийг урт хугацаанд амжилттай хэрэгжүүлэхэд донор байгууллага болон Засгийн газрын дэмжлэг зогссоны дараа орон нутгийн сонирхлыг идэвхжүүлж, тогтвортой үргэлжлүүлэх нь гол хэрэгсэл болно. Орон нутгийн болон үндэсний түвшний санхүүжүүлэгчидтэй хамтарч алтны бичил уурхайн бизнесийг санхүүжүүлэх ажилд оролцуулснаар дотоодын туршлага хуримтлуулахаас гадна бусад хөгжиж байгаа салбарт хүрч хүрээгээ тэлэх боломж бүрдүүлнэ. Ийм байгууллагуудтай хамтарч ажиллахад геологийн болон хүн ам зүйн байдлын талаарх мэдээллийг бэлэн байлгаснаар тэдний сонирхолыг нэмэгдүүлж яваандаа, орон нутгийн хөрөнгө оруулалтыг хурдасгана.

► **Алтны бичил уурхайн төслүүдийн үнэлгээний талаар санхүүжүүлэгч байгууллагуудын мэдлэг, мэдээллийг сайжруулах.**

Санхүүжүүлэгч байгууллагууд алтны бичил уурхайн салбарыг олон нийтийн дунд байдаг ерөнхий сөрөг хандлагад үндэслэн эрсдэлтэй гэж үздэг байх талтай. Иймээс эдгээр байгууллагуудын гол шийдвэр гаргагчдад бичил уурхайн салбарын боломжийн талаар зөв ойлголт өгснөөр энэ буруу ойлголтыг халж, амжилттай хамтран ажиллах боломж бүрдэнэ. Алтны бичил уурхайн тухай үндсэн ойлголт өгөх, олборлох боломжтой алтны хэмжээ болон үүнээс олох ашиг орлогын талаар ярилцсанаар уг байгууллагын бичил уурхайчдын талаарх сонирхолыг өдөөх боломжтой юм. Алтны бичил уурхайн салбар болон санхүүжүүлэгч байгууллага хоёр хоорондоо мэдлэг мэдээлэл солилцох хэрээр бие биенийхээ хэрэгцээ шаардлагыг илүү ойлгодог болно.

► **Алтны бичил уурхайн зорилтот бүлэгт тохирсон зээлийн бүтээгдэхүүн гаргах.** Санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг алтны бичил уурхайчдын одоогийн хэрэгцээ шаардлага болон чадварт дүйцүүлэн гаргаж, санхүүжилтийн багцын хэмжээ болон нөхцөл нь тэдний үйл ажиллагааны хэмжээнд таардаг байх шаардлагатай. Жишээлбэл, зээлийг концессын нөхцөлтэй загварчлах, эсвэл хугацааг сунгах боломжтой, эргэн төлөлтийн хуваарийг урт хугацаагаар хийх гэх мэтээр бичил уурхайчдын бодит байдлыг тусган хийх нь чухал юм. Ингээгүй тохиолдолд оролцогч талуудад аль алинд нь хүндрэлтэй байна. Өнгөрсөн хугацаанд олборлосон алтны түүх, бүртгэлийг ашиглан тухайн газраас ирээдүйд олборлож болох алтны хэмжээг тодорхойлох гэх мэтээр барьцаа хөрөнгө гаргах талаар санаачилгатай ажилласнаар алтны бичил уурхайчид санхүүжилт авах бусад эх үүсвэрийг нээх боломжтой. Үүнд барьцаа хөрөнгийн өөр эх үүсвэр, бага хувьтай хүү, бага урьдчилгаа төлбөр, эргэн төлөлтийн уртасгасан хугацаа, олборлолт эхлэх хүртэл эргэн төлөлтийг хойшлуулах болон эргэн төлөлтийг улирлын чанартай хийх гэх мэт тусгай нөхцөлийг тусгаж болно. Түүнчлэн, геологийн судалгаа, баримтын оронд олборлосон алтны бүртгэлийг ашиглах гэх мэт алтны нөөц байгаа гэдгийг батлах, боломжит ашиг орлогын баримтжуулалтыг өөр хэлбэрээр хийх боломж ч бий.

► **Эрсдэлийг багасгах зорилгоор эрсдэлийг хамтран үүрэх, бүлгээрээ хамтран ажиллах, хоршоо байгуулах зарчмыг тусгах.** Хэдийгээр хамтран ажиллах туршлага бүрдээгүй газар хамтран ажиллахыг хүчлэх нь зохимжгүй боловч нөхцөл байдал бүрдсэн үед санхүүжилтийн эрсдэл болон хариуцлагыг олон бүлэг хамтран үүрэх нь илүү амжилттай стратеги байсныг өмнөх туршлага харуулж байна.

► **Холимог санхүүжилтийг дэмжих.** Өмнө дурдсанчлан аливаа улсын засгийн газар болон донор байгууллагууд хамтран зээлийн болон барьцаа хөрөнгийн баталгаа гаргах замаар зээлийн болон хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулахад туслалцаа үзүүлэх боломжтой. Жишээлбэл, үндэсний хөгжлийн банкны хөрөнгөөр орон нутгийн банкнаас зээл авах баталгаа гаргаж болно.

5.5 Алтны бичил уурхайн салбарт хувийн хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах

Алтны бичил уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт, сонирхол татахуйц ашиг орлого, өмнөх амжилтын талаарх бүртгэл, тоо баримт, орон нутгийн удирдлагын чадвартай баг шаардлагатай бөгөөд эдгээр нь бүгд бичил уурхайн байгаль орчин,

нийгэм, засаглалын болон нэр хүндтэй холбоотой эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулдаг. Алтны бичил уурхайн салбарт илүү их хөрөнгө оруулалт татах зорилгоор доорх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

► **Хөрөнгө оруулалт хийхэд бэлэн болсон төслүүдийг хөгжүүлэх.** Хөрөнгө оруулагчдын шаардлагыг хангаж санхүүжүүлэхэд бэлэн болсон төслүүдийг тодорхойлсноор хөрөнгө оруулагчдын оролцоог идэвхжүүлэх боломжтой. Санхүүжүүлэгчдээс төсөлд ихэвчлэн тавьдаг шаардлагад төслийн хэмжээ, үүнээс гарах ашиг, орлого, баталгаатай байдал, бүс нутаг, үүнээс гарах эерэг нөлөө (нөлөөллийн санхүүжүүлэгчдийн хувьд) болон эрсдэлийг тооцсон ашиг зэрэг орно.

○ **Хөрөнгө оруулалтын хэмжээ.** Аливаа хөрөнгө оруулалтын нөхцөлд хамгийн бага болон хамгийн их хөрөнгө оруулалтын хэмжээг тусгасан байдаг. Алтны бичил уурхайн бие даасан үйлдвэрлэлд ойролцоогоор 10-100 мянган ам.долларын хөрөнгө оруулалт хангалттай байдаг бол бичил уурхайн байгууллагууд нэгдэж ажилладаг эсвэл төвлөрсөн төсөлд үүнээс их буюу 1-2 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байж болно. Эдгээр үнийн дүн нь томоохон хөрөнгө оруулалт хийдэг олон хөрөнгө оруулагчдын хувьд бага тоо юм.

○ **Олохыг зорьж буй ашиг орлого.** Ашгийн төлөө бус болон нөлөөллийн хөрөнгө оруулагч л биш бол ихэнх хөрөнгө оруулагчид зах зээлийн жишгээр ашиг олохыг эрмэлздэг. Донор, буцалтгүй тусламж болон нөлөөллийн хөрөнгө оруулалт гэх мэт санхүүжилтийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд ашиг орлого олохыг чухалчлахгүй байх талтай.

○ **Баталгаатай байдал.** Зээлийн санхүүжилт хийж байгаа тохиолдолд ихэнх хөрөнгө оруулагчид үнэ цэнэтэй хөрөнгө барьцаалахыг шаарддаг. Үүнийг хангах боломжгүй тохиолдолд тэд ямар нэгэн баталгаа гаргагчаас учирч болзошгүй хохирлын зарим хэсгийг батлан даахыг хүсэх талтай. Хөрөнгө оруулалт эрж хайхаасаа өмнө ямар нэгэн хэлбэрээр барьцаа, эсвэл баталгаатай болох нь санхүүжилт олдохгүй байх эрсдэлийг бууруулдаг бөгөөд зарим хөрөнгө оруулагчид үүнийг эхний шаардлага болгодог. Иймээс шаардлагатай санхүүжилтэд хэдий хэмжээний барьцаа хөрөнгө, эсвэл ямар баталгаа шаардлагатайг урьдчилан мэдэх нь үйл явцыг хурдасгахад тустай.

○ **Бүс нутаг.** Олон хөрөнгө оруулагчид өөрсдийн хөрөнгө оруулах журамдаа газарзүйн байршлын болон хууль эрхзүйн хязгаарлалт тавьдаг. Энэ нь тулгарч болзошгүй эрсдэл, эсвэл зөрчил мөргөлдөөнтэй бүс нутаг гэх мэт хөрөнгө оруулалт хийхийг хориглосон журмын дагуу гаргасан шийдвэр юм.

○ **Нөлөө.** Албан ёсны санхүүжилтийг тухайн хөрөнгө оруулалтаас хүлээгдэж байгаа ашгийн хэмжээ болон “нөлөөлөл нэгдүгээрт” эсвэл “ашиг нэгдүгээрт” гэсэн зарчмыг харгалзан үзэж ангилж болно. Банкууд, хувийн хэвшил болон уул уурхайн сан гэх мэт ашгийн төлөө буюу ашиг чухалчилдаг хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгөөсөө аль болох их ашиг орлого олохыг эрмэлздэг. Харин нөлөөллийн хөрөнгө оруулагчид буюу нөлөөлөл чухалчилдаг хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгө нь аль болох хэмжигдэхүйц үр дүнтэй нөлөө үзүүлэхийг хүсдэг бөгөөд тэдний хувьд үүнээс ашиг орлого олно гэхээсээ илүү эерэг үр дүн гаргах нь чухал байдаг. Нөлөөллийн санхүүжилт нь гарч байгаа эерэг үр дүнг харуулах тодорхой шалгуур үзүүлэлт дээр суурилсан байдаг.

○ **Эрсдэлийн эсрэг ашиг орлого.** Хөрөнгө оруулагчид тухайн төсөлд тулгарч болзошгүй эрсдэлийг түүнээс ирэх ашиг орлоготой үргэлж харьцуулж үздэг. Өндөр эрсдэлтэй атлаа ашиг орлого багатай төсөл нь эрсдэлээ багасгах эсвэл ашгаа нэмэх ёстой. Эсвэл хоёуланг нь хийхийн төлөө ажиллах хэрэгтэй. Алтны бичил уурхайн салбарын тухайд үргэлж бодит болон буруу ойлголтоос үүссэн хийсвэр эрсдэл оршиж байдаг бөгөөд албан ёсны санхүүжилт, хөрөнгө оруулалт татахын тулд үүнийг заавал багасгах, сааруулах шаардлагатай байдаг. Хэрэв аливаа эрсдэл буруу ойлголтоос үүссэн бөгөөд түүнийг багасгах, зохицуулах боломжтой бол бодит эрсдэл нь харьцангуй бага байж болох юм. Жишээлбэл, Африкийн зарим бүс нутагт ажилладаг бичил уурхайг хөрөнгө оруулагчдын зүгээс өндөр эрсдэлтэй гэж үзэж байхад үнэн хэрэгтээ тэдгээр эрсдэлийг зохицуулах, арилгах боломжтой байвал эрсдэлийн бодит хэмжээ нь харьцангуй бага байсан гэж үздэг.

► **Шинэ салбарт анхлан хөрөнгө оруулагчид болон шинийг санаачлагчдыг онилох.** Алтны бичил уурхайн төслүүд шинэ салбарт эртнээс хөрөнгө оруулагчид болон шинийг санаачлагчдаас хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг эрж хайх нь санхүү, хөрөнгө оруулалтын нийт салбарт хэт өргөн хүрээнд ажиллаж, боломж нөөцөө шавхсанаас илүү үр дүнтэй байдаг. Өндөр ашиг, орлоготой хүмүүс болон гэр бүлийн бизнесийнхэн ихэвчлэн шинийг санаачилж нөлөөллийн хөрөнгө оруулах хандлагатай байдаг. Мөн түүнчлэн хувийн том уурхай, эсвэл сан, уламжлалт уул уурхайн санхүүжилт, уул уурхайн сөрөг нөлөөг бууруулах сан гэх мэт хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд хөрөнгө босгохыг чухалчлан үздэггүй. Бидний судалгааны үр дүнгээр алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах магадлалтай хүмүүс дараах үндсэн шалтгаанаар уг шийдвэрийг гаргадаг байна. Үүнд: зорилго, эсвэл хэтийн төлөв, боломжийн ашиг орлого олох, эсвэл эрсдэлээс айдаггүй байх гэх мэт шалтгаанууд орно. Зарим нь эрсдэлээс холуур байхыг хүсдэг бусад хөрөнгө оруулагчдыг алтны бичил уурхайн салбарын хөрөнгө оруулалтад татан оролцуулж, зөвхөн тухайн үйлдвэрлэлийн хувьд бус бүтэн салбарын түвшинд эерэг нөлөө гаргасан нь хөрөнгө оруулалтын үр ашгийн нэлээд хэсэг нь хэмээн үздэг.



Гэрэл зургийг НУБАҮХБ

5.6 Бичил уурхайчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх

Алтны бичил уурхайчид бизнес менежментийн зохих чадварт суралцаж яваандаа өөрийнхөө үйл ажиллагаанд тулгуурлан албан ёсны санхүүжилтийн хүсэлт гарган, татах чадвартай болох хэрэгтэй. Бичил уурхайчдын чадавхийг бэхжүүлэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

► **Санхүүгийн хэрэгцээ шаардлага болон хэмжээгээ тодорхойлоход нь туслах.** Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг оновчтой тодорхойлсноор яг ямар төрлийн санхүүжилтийг хаанаас эрж хайх вэ гэдгийг тогтооход ач холбогдолтой. Алтны бичил уурхайн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага болон хэмжээ нь боломжит санхүүгийн эх үүсвэрийн зөвшөөрөгдсөн хэмжээтэй дүйцэх ёстой. Алтны бичил уурхайн байгууллагууд арилжааны байгууллагаас санхүүжилт авах, түүнийг ашиглах, зохицуулах талаарх өөрсдийн чадвар, хөрөнгө санхүүгийн хэрэгцээ шаардлага, зээл, санхүүжилтийн хүлээн авч болох эсвэл болохгүй нөхцөлийг сайтар ойлгох ёстой. Байгууллагынхаа чадавхыг ойлгож мэдсэнээр алтны бичил уурхайн байгууллагууд өөрийн нөхцөл байдалдаа тохирсон санхүүжилтийн эх үүсвэрийг эрж хайх бөгөөд энэ нь цаашдаа санхүүжүүлэгч, зээлдэгч хоёрын хамтын ажиллагаанаас хүлээх ялгаатай хүлээлттэй холбоотой эрсдэлийг багасгах ач холбогдолтой юм.

► **Бизнесийн төлөвлөгөө ашиглан асуудлыг шийдвэрлэхэд сургах.** Хөрөнгө оруулагчид эрсдэлийг тус бүрдээ хэрхэн үнэлж байгааг ойлгосноор алтны бичил уурхайн байгууллагууд тулгарсан эрсдэлийг үр дүнтэй бууруулснаар өөрсдийн стратегийг холбогдох хөрөнгө оруулагчдад танилцуулах боломжтой болно. Арилжааны эх үүсвэрээс албан ёсны санхүүжилт хайж байгаа алтны бичил уурхайн байгууллагууд ашиг орлого олох боломж, шаардлагатай хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл, ашиг олох арга зам зэргийг тодорхой тусгасан бизнесийн төлөвлөгөө боловсруулсан байх ёстой. Бизнесийн төлөвлөгөөг ямар ч хэлбэрээр хийж болох боловч тухайн төслөөс гарах үр дүн, боломжийн тухай үнэлгээг заавал тусгасан байна. Албан ёсны санхүүжүүлэгч болон хөрөнгө оруулагчид энэхүү бизнесийн төлөвлөгөөнөөс төслийн талаар ойлголттой болохоос гадна энэ баримт бичиг нь тухайн хөрөнгө оруулагчид магадлан шинжилгээ хийхэд нь чухал үүрэгтэй. Түүнчлэн бизнесийн төлөвлөгөөнд тухайн төслийн үр ашгийг илэрхийлж болох бүх хүчин зүйлийг маш тодорхой тусгана. Хөрөнгө оруулалтаас гарах ашгийг тодорхойлох хүчин зүйлд уурхайн талаарх мэдээлэл (үйлдвэрлэл, бэлэн

мөнгөний урсгал, ажилчдын талаарх мэдээлэл); яагаад хөрөнгө оруулалт хэрэгтэй болсон тухай; оруулсан хөрөнгийг юунд зарцуулах тухай; хөрөнгө оруулбал ямар ашиг олж болох тухай; хөрөнгө оруулалтын нөхцөл; хөрөнгө оруулалт авснаар тухайн байгууллагад ямар ач холбогдолтой, ашиг тустай байх тухай (эдийн засгийн хөгжил, шаардлагатай тохиолдолд үүнээс гарах хэмжигдэхүйц эерэг нөлөө гэх мэт); тухайн төслийн хүрээнд олборлож болох алтны хэмжээ; тулгарч болзошгүй эрсдэл ба энэхүү эрсдэл тулгарах хамгийн муу нөхцөл болон хамгийн гайгүй сайн нөхцөлийн үеийн үнэлгээ; эрсдэлийг сааруулах, боломжит хэмжээнд хүртэл багасгах арга хэмжээ; болон санхүүгийн алдагдалд орсон тохиолдолд хэрхэн барагдуулах тухай баталгаа гаргагчтай хамтарсан мэдэгдэл зэрэг байна. Хөрөнгө оруулалт нь тухайн байгууллагын бизнесийн хөгжил болон ашиг орлогыг хэрхэн дэмжих талаар тодорхой дүрсэлснээр алтны бичил уурхайн байгууллага зээлээ төлж барагдуулна гэсэн итгэлийг бий болгож, зээлийн эргэн төлөлтийн хугацаа болон боломжийн хүү тогтоох талаар хэлэлцэж, ойлголцолд хүрэх нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн алтны бичил уурхайн байгууллага уг хөрөнгө оруулалтаас тухайн төслийн хүрээнд, эсвэл орон нутгийн түвшинд байгаль орчин, нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэж, хэмжигдэхүйц эерэг нөлөө үзүүлж болох талаар тодорхойлж болно. Хэрэв хэмжигдэхүйц үр нөлөө гарах боломжтой бол нөлөөллийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг эрж хайн, хамтарч ажиллах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй. Бичил уурхайчдын итгэлийг олж чадсан байгууллага, бүлгүүд нь бичил уурхайчидтай холбоо тогтоож, тэдний санхүүгийн болон бусад чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэсний түвшний алтны бичил уурхайн байгууллага, холбоог оролцуулж, эрх мэдэлжүүлснээр бүх түвшний хамтрагч талууд, оролцогчдыг хооронд нь холбох, тэдэнтэй харилцах, тэдэнд хүрч ажиллах үүргийг хариуцах боломжтой.

► **Оролцооны аргыг түлхүү ашиглах.** Өөрсдийн санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог алтны бичил уурхайн байгууллагуудын хувьд нийгмийн болон санхүүгийн үр дүн/нөлөө, ашиг олох боломж нь үргэлж өндөр байдаг. Алтны бичил уурхайн байгууллагууд өөрийнхөө бизнесийн үйл ажиллагааны боломжийг нэмэгдүүлэхэд юу хэрэгтэй байгаа талаар сайн мэддэг бөгөөд зээлийн эргэн төлөлтийн нөхцөлийг тогтооход бодит мэдээллээр хангаж хувь нэмэр оруулах боломжтой. Жишээлбэл, борооны улиралтай бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчид зээлийн эргэн төлөлтийн график зохиохдоо борооноос болж үйл ажиллагаа түр зогсох эрсдэлийг тусгах, эсвэл эргэн төлөлтийн хугацааг уртасгах талаар хүсэлт гаргаж болох юм.

► **Санхүүжилтийг идэвхжүүлэх дундын зуучлагчдыг хөгжүүлэх.** Донор байгууллагууд, ТББ болон нийгэмд үйлчилдэг байгууллагууд бичил уурхайн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх ажлыг идэвхжүүлэх чиглэлээр техникийн туслалцаа үзүүлж, сургалт зохион байгуулан, чадавх бэхжүүлэхээс эхлээд зуучлагч, брокерийн үүрэг гүйцэтгэж, тархай бутархай ажиллаж байгаа бичил уурхайн байгууллагуудыг нэгтгэх гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр дэмжин ажиллах боломжтой. Алтны бичил уурхайн байгууллагууд зөвхөн орон нутгийн зээлдүүлэгч, санхүүжүүлэгчдээ мэддэг, санхүүгийн боловсрол дутмаг, бага хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай учир их хэмжээний зээлтэй холбоотой асуудлыг зохицуулах боломжгүй байж болно. Магадгүй тэд албан ёсны санхүүжилтийн тогтолцоонд итгэдэггүй бөгөөд зөвхөн найдвартай албан бус үйл ажиллагаа явуулдаг, таньж мэддэг хүмүүсээ түших хэлбэрээр хувийн бизнесийн харилцааг илүүд үзэх магадлалтай.

Бичил уурхайн байгууллагууд албан ёсны санхүүжилт, нийгмийн энтэрпренер, нийгмийн санхүүжилтийн зуучлагч,



Гэрэл зургийг НҮББОХ

буяны байгууллагууд, ТББ, хөгжлийн болон засгийн газрын агентлаг болон хөтөлбөрүүдийн талаар илүү туршлагатай болтол орон нутгийн банк болон бусад талууд алтны бичил уурхайн байгууллага болон санхүүжүүлэгчдийн хооронд гүүр болохуйц үйлчилгээ үзүүлэх нь зүйтэй. Түүнчлэн алтны бичил уурхайн байгууллагуудын санхүү, бизнесийн боловсрол хангалттай дээшилж бие даах хэмжээнд хүртэл нь тэдний санхүүгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, танилцуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах хэрэгтэй. Мөн алтны бичил уурхайн олон жижиг нэгжүүдийн хөрөнгө санхүүгийн хэрэгцээг нэгтгэж цааш нь шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйлчилгээг зуучлагчид нь хүргэх боломжтой. Бичил уурхайн үйлдвэрлэлийн жижиг нэгжүүдтэй ажиллах үед тэднийг дээрх байдлаар нэгтгэх шаардлага гардаг. Учир нь алтны бичил уурхайн бизнесүүдийн шаарддаг зуу зуун мянган ам.долларын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг ихэнх хөрөнгө оруулагчид магадлан шинжилгээ, мониторинг, тайлагнал болон эргэн төлөлтийг цуглуулах гэх мэт үйл ажиллагааны зардлууд нь тухайн хөрөнгө оруулалтаас ирэх ашигтай харьцуулбал харьцангуй өндөр байдаг учраас эдийн засгийн ашиггүй хөрөнгө оруулалт гэж үздэг. Алтны бичил уурхайн жижиг бизнесүүдийг нэгтгэж зээл, хөрөнгө оруулалтын багц бэлтгэх, эсвэл төвлөрсөн баяжуулах цех байгуулах гэх мэт томоохон үйл ажиллагаанд хөрөнгө санхүүжилт авах боломж нь арай өндөр байдаг.

► **Бичил уурхайчдыг алхам алхамаар санхүүгийн мэдлэг, туршлагатай болгох.** Бичил уурхайчдын бизнесийн туршлага болон санхүүгийн менежментийн чадавхыг дараах арга замаар хөгжүүлж болно. Үүнд: санхүүгийн боловсрол олгох, санхүү бүртгэлийн тогтолцоо бүрдүүлэхэд нь туслах, бизнесийн загвар боловсруулж хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаа тодорхойлоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа орно. Алтны бичил уурхайн салбарын санхүү, хөрөнгө оруулалт, бүртгэл хөтөлөлтийн талаарх мэдлэг чадавхыг хөгжүүлэхэд цаг хугацаа шаардагдана. Жишээлбэл, орон нутгийн сан, зээлийн холбоо гэх мэт орон нутгийн аж ахуйн нэгжүүд бичил уурхайн байгууллагад санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн наад захын бүртгэл тооцоо хөтлөхөд сургаж, хувь нэмэр оруулах бөгөөд илүү найдвартай, үр дүнтэй үйлдвэрлэлийн технологи зэрэг мэдлэг мэдээллийг сургалт, мэдлэг түгээх төвийн үүрэг гүйцэтгэдэг хүдэр баяжуулах цех, баяжуулах үйлчилгээгээр хүргэх нь мэдээлэл дамжуулах үр дүнтэй арга байж болно. Алтны бичил уурхайн байгууллага хангалттай түвшний техникийн ноу-хау мэдлэг болон санхүүгийн боловсролтой болсон цагт орон нутгийн банк, магадгүй санхүүгийн шинийг санаачлагчдаар (нийгмийн төлөө ажилладаг бизнесийн байгууллагууд, ашиг орлого өндөртэй хувь хүмүүс, нийлүүлэлтийн сүлжээний дунд хэсэгт ажилладаг байгууллагууд болон хөгжиж байгаа салбарт эртнээс хөрөнгө оруулдаг нөлөөллийн хөрөнгө оруулагчид гэх мэт) дамжуулан бичил зээлийн сан, хосолсон санхүүжилтийн сангаас жижиг зээл авах боломжтой болно. Алтны бичил уурхайн болон санхүүжилтийн салбар аль аль нь хөгжсөн цагт алтны бичил уурхайн байгууллагууд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай боломжийн хэмжээний зээлийг банкнаас авах боломжтой болно.

Зээл авах боломжгүй, эсвэл хүсэлгүй алтны бичил уурхайн байгууллагууд болон мөнгөн усгүй технологи нэвтрүүлэхэд шаардлагатай урьдчилгаа төлбөрийн асуудалтай байгаа байгууллагуудын хувьд урьдчилгаа их мөнгө төлөлгүйгээр лизингээр тоног төхөөрөмж авах нь бичил уурхайчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах хамгийн тохиромжтой арга болно. Дээрх сургалтуудтай хосолсон лизингийн хөтөлбөрүүд нь бичил уурхайчдад санхүүгийн боловсрол олгох, бүртгэл тооцоонд сургах анхны алхам болж болно.

► **Магадлан шинжилгээний үнэлгээгээр гарсан эрсдэлийг арилгахад нь алтны бичил уурхайн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх.** Санхүүгийн болон бусад байгууллагууд магадлан шинжилгээг уул уурхайн бизнесийн дэвшил, байгаль орчин, нийгмийн болон засаглалтай холбоотой эрсдэлийг үнэлэхэд магадлан шинжилгээг ашигладаг. Байгаль орчин, нийгмийн болон засаглалтай холбоотой эрсдэлээс зайлсхийдэг, эсвэл тулгарсан тохиолдолд бууруулж чаддаг алтны бичил уурхайн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон алт худалдан авагчдын анхаарлыг илүү татдаг. Магадлан шинжилгээний үнэлгээний талаарх нийтлэг мэдлэгтэй болох нь бичил уурхайчдад холбогдох байгаль орчин, нийгмийн болон засаглалтай

холбоотой эрсдэлийг сааруулах, үйл ажиллагаагаа шаардлагын дагуу баримтжуулах ажлыг хийхэд дөхөм болгоно. Бичил уурхайчдын байгууллагад ЭЗХАХБ-ын хариуцлагатай эрдэс баялгийн нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж²⁴ гэх мэт магадлан шинжилгээний шалгуур үзүүлэлтийг хангах, байгаль орчин, нийгмийн болон засаглалтай холбоотой эрсдэлийг бууруулах шалгуур үзүүлэлтүүдийг хангах зорилгоор баримт цуглуулах, үйл ажиллагаагаа баримтжуулах зэрэг сэдвээр тусгай сургалт зохион байгуулах шаардлагатай.

5.7 Алтны бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор салбарын бусад оролцогчдыг чадавхжуулах

Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч талууд уг салбарын мэргэжлийн хөгжил болон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

► **Алтны бичил уурхайчдыг чадавхжуулж, мэргэшүүлэх зорилгоор уул уурхайн компаниуд болон бичил уурхайн хоорондын харилцааг сайжруулах.** Үр дүнтэй баяжуулах арга технологи, аюулгүй байдал, нэмүү өртөг бий болгох болон бизнесийн ур чадварын талаарх мэдлэг туршлагаа том болон дунд хэмжээний уурхайн компаниуд бичил уурхайчидтай хуваалцах, дамжуулах боломжтой. Үүнийг үр дүнтэй хийхийн тулд уул уурхайн компани болон бичил уурхайн байгууллага хоорондоо итгэлд суурилсан харилцаа холбоотой байх ёстой. Хэдийгээр энэ нь урт хугацааны шийдэл биш байж болох ч эдгээр хамтын ажиллагааг илүү бие даасан, мэргэшсэн, тогтвортой, албан ёсны зөвшөөрөлтэй бичил уурхайн салбарыг хөгжүүлэх нэг алхам гэж үзэж болно.

► **Зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн иргэдийн хяналтыг ашиглах.** Санхүүжилтийн эргэн төлөлтийг амжилтад хүргэх нэгэн гол хөдөлгөгч хүч нь зээлдэгчийн үйл ажиллагааг хянах боломжтой байх явдал юм. Гана, Суринам зэрэг улсын туршлагаас харахад орон нутгийн иргэдийг алтны бичил уурхайн олборлолтын газарт хяналт хийлгэхээр томилсон нь тодорхой амжилтад хүрчээ. Орон нутгийн итгэл даасан алт худалдан авагчид, нутгийн зөвлөл, орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн банкууд (хэрэв тэд зээлдүүлэгчид бол) болон бусад холбогдох талуудыг орон нутгийн хяналтын ажилтнаар сургаж чадавхжуулан ажиллуулж болно.

Хэдий тийм ч зарим зээлдүүлэгчдийн хэлснээр ийм хянагчид зарим тохиолдолд амархан хээл хахуульд өртдөг учраас хэд хэдэн талыг төлөөлсөн олон хянагчид ажиллуулах систем бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

24 <https://www.oecd.org/daf/inv/mne/mining.htm>



► **Итгэлцэлд суурилсан хамтын ажиллагааг харгалзан үзэх.** Санхүүжилтийн шинэ хөтөлбөр, схем санал болгохын тулд тухайн орон нутгийнхны дунд итгэлд суурилсан хамтын ажиллагаа, харилцаа холбоо байдаг эсэх талаар судлах нь зүйтэй. Ялангуяа, албан бус санхүүжилтийг орон нутгийн алтны худалдаачид гүйцэтгэдэг бол тэдгээрийн ажил үүргийг шинэ хөтөлбөр боловсруулах үйл явцад харгалзан үзэх нь чухал юм. Алтны бичил уурхайн санхүүжилтийн шинэ системээр дамжуулан дээрх харилцааг бүрэн хуулбарлан тусгах боломжгүй Албан ёсны системд итгэх итгэл дутмаг байдгаас үүдэн дээрх итгэлцэлд суурилсан хамтын ажиллагаа үүсч бий болдог бөгөөд үүнийг ганц шөнийн дотор цуцалж, солих боломж мөн хомс. Тиймээс зуучлагчдад өөр үүрэг, хариуцлага оногдоогүй тохиолдолд тэд байр сууриа алдахад хүргэх өөрчлөлтийг үгүйсгэхийн тулд идэвхтэй ажиллах магадлалтай.

5.8 Үр дүнг баримтжуулах

Алтны бичил уурхайн үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ хэлбэр бүрийн үйл явцыг нарийн тодорхой бичиж тэмдэглэн баримтжуулж амжилт, алдаа, оноог нь дүгнэж үнэлэх, дараагийн төслүүдэд ашиглах туршлага болгох нь зүйтэй юм. Тухайн үйл ажиллагааны амжилтын шалгуур нь:

- Санхүүжилтийн хэлбэр;
- Санхүүжилтийн багцуудын тоо;
- Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ (амжилттай төлсөн төлбөрүүд болон зээлийн эргэн төлөлт);
- Дэмжлэг үзүүлсэн хүний тоо;
- Дэмжигдсэн санхүүжилтийн хүсэлтийн тоо; болон
- Үйл ажиллагаанд гарсан бодит өөрчлөлт, гэрч баримттай байна.

Түүнчлэн санхүүжилтийн үйл ажиллагааны цогц тоо баримт тодорхой болсны дараа санхүүжилтийн хүсэлт гаргасан өргөдлийн тоо, эдгээрээс амжилттай хэрэгжсэн хүсэлтийн тоо, үүнээс ашиг шимийг нь хүртсэн бичил уурхайн байгууллага, бичил уурхайчдын тоо гэх мэт бодит нөлөөллийн тоо баримт, мэдээллийг нэгтгэж баримтжуулах нь зүйтэй. Эдгээр тоо баримт, мэдээллийг цуглуулан шинэ төсөл хэрэгжих бүрд байнга шинэчилж ашиглах нь эерэг хүрээлэл үүсгэх үндэс суурь болно. Мэдээлэл, тоо баримт их байх тусам нөхцөл байдал тодорхой болох бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг илүү татаж, нөхцөл байдал сайжрахаас гадна оролцоо нэмэгдэн үүнтэй хамт мөнгө, санхүүжилт ирнэ.

5.9 Санхүүжүүлэлт татахад тулгардаг саад бэрхшээлийг даван туулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний хураангуй

Дараах арга хэмжээ нь алтны бичил уурхайн байгууллагын хувьд санхүүжилт татахад тулгардаг болон хөрөнгө оруулагчдын хувьд алтны бичил уурхайн байгууллагатай холбоотой ажиллахад тулгардаг саад бэрхшээлийг зохицуулахад хувь нэмэр болно. Хүснэгт 2-т Засгийн газар, донор байгууллагууд болон бусад хамтрагч талуудаас тулгарч болзошгүй саад бэрхшээлийг зохицуулахад шаардлагатай арга хэмжээг нэгтгэсэн болно.

Хүснэгт 2. Санхүүжилт татахад тулгарч болзошгүй саад бэрхшээлийг даван туулахад хэрэгжүүлж болох арга хэмжээний хураангуй

Албан ёсны хөрөнгө оруулалтад тулгарч байгаа бэрхшээл		Засгийн газар, донор байгууллагууд, бусад талуудын зүгээс хэрэгжүүлж болох арга хэмжээ
Алтны бичил уурхай	Санхүүжүүлэгч	
Албан бус үйл ажиллагаа	Нэр хүндэд сэргөөр нөлөөлөх/байгаль орчин, нийгэм, засаглалын хувьд сөрөг нөлөө үзүүлэх	- Орон нутаг, бүс нутаг, үндэсний шийдвэр гаргах түвшинд алтны бичил уурхайн салбарын үйл ажиллагааг албажуулах, мэргэшүүлэх үйл явцыг хурдасгах - Илүү тогтвортой уурхайн технологи нэвтрүүлэхэд уул уурхайн компаниудтай хамтран техник тусалцаа үзүүлэх - Алтны бичил уурхайн талаарх сөрөг ойлголтыг багасгах зорилгоор зөв хандлагатай олон нийтийн хэвлэл мэдээллийг дэмжих
Магадлан шинжилгээний шаардлагыг хангах боломжгүй	Магадлан шинжилгээний шаардлагыг хангахад өндөр өртөгтэй	- Бичил уурхайчдад магадлан шинжилгээний үнэлгээний талаарх нийтлэг ойлголт өгөх - Холбогдох эрсдэлийг арилгах, багасгах талаар бичил уурхайчдад тусалж магадлан шинжилгээний шаардлагыг хангахад нь дэмжлэг үзүүлэх. Үүнд байгаль орчин, нийгэм болон засаглалын талаарх суурь судалгаа хийж өөрчлөлтийг хянаж мониторинг хийх зэрэг үйл ажиллагаа багтана.
Алтны бичил уурхайн байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангасан санхүүжилтийн бүтээгдэхүүн хомс байдаг (хэт үнэтэй, нөхцөл өндөртэй, үйл ажиллагааны бодит байдалд зохицдоггүй)	Салбарын үйл ажиллагааг сайн ойлгож мэдээгүй, алтны бичил уурхайн үйл ажиллагааны талаарх мөшгөсөн судалгаа, мэдээлэл байхгүй	- Одоогийн алтны бичил уурхайн ажиллаж байгаа газар нутгийн талаарх тоон мэдээлэл цуглуулах: хүн амын тоо, геологийн бүтэц, нийлүүлэлтийн сүлжээ болон бичил уурхайн үйл ажиллагаанд одоо үзүүлж байгаа санхүүгийн үйлчилгээ болон энэ бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг бусад жижиг, дунд үйлдвэрлэл - Алтны бичил уурхайг санхүүжүүлэгч байгууллагуудад тодорхой ойлголт өгөх - Алтны бичил уурхайн хэрэгцээ шаардлагад санхүүгийн эх үүсвэрийг тохируулах - Эрсдэлд хүлээцтэй ханддаг хөгжиж байгаа шинэ салбарыг сонирхон, шинийг эрэлхийлэгчдээс хөрөнгө оруулалт авах боломжийг эрж хайх - Зээлийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эрсдэлийг багасгах зорилгоор холимог санхүүжилт хийх - Алтны бичил уурхайн чадавхад тохирсон санхүүжилтийн бүтэц, механизм хөгжүүлэх (жишээлбэл, эргэн төлөлтийн улирлын чанартай, эсвэл улирал алгасч төлөх систем, барьцаа хөрөнгийн хоёрдогч эх үүсвэр гаргах гэх мэт) - Санхүүгийн бүтээгдэхүүний загвар гаргах үйл явцад бичил уурхайчдын оролцоог нэмэгдүүлснээр тэдний нөхцөл байдалд илүү тохирсон бүтээгдэхүүн гаргах - Тулгарч болзошгүй эрсдэлийг аль болох олон талууд хувааж үүрэх - Зээлийн эргэн төлөлтийн хяналтыг орон нутгийн иргэдийн оролцоотой хийх - Бичил уурхайчдын санхүүгийн бүртгэл тооцоог нягт тодорхой хийх - Санхүүжилтээс гарсан үр дүн, зэрэг нөлөө болон ашиг орлогын талаарх тоон мэдээллийг баримтжуулах
Бизнесийн туршлагын талаарх мэдээлэл, тоо баримт дутмаг	Хөрөнгө оруулалт татахад бэлэн болсон төсөл дутмаг	- Олборлолтын үйл ажиллагаатайгаа уялдуулан хөрөнгөө үнэлэхэд нь шаардлагатай геологийн болон техникийн мэдлэг чадварыг бичил уурхайчдад олгох - Бичил уурхайчидтай холбогдох, тэднийг сургахад одоо байгаа итгэлцэлд суурилсан харилцаа холбоог ашиглах - Бичил уурхайн салбарын санхүүгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, бизнесийн төлөвлөгөө боловсруулахад бичил уурхайчдын өөрсдийнх нь мэдлэг, мэдээллийг ашиглах - Хөрөнгө оруулагчдын шалгуурыг хангаж, хөрөнгө оруулалт хийхэд бэлэн болсон төслүүдийг тодорхойлж, бэлтгэх - Бичил уурхайчдын санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэн, талуудтай холбож, гүүр болох зуучлагч байгууллагуудыг тодорхойлон, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (нийгмийн энтрепренер байгууллага, иргэний нийгмийн байгууллага) - Санхүүжилт олгохоос гадна төрөл бүрийн бизнесийн үйлчилгээг бичил уурхайчдад хүргэх
Үйл ажиллагааны цар хүрээ	Бага хэмжээний санхүүжилтийн шилжүүлгийн үнэ	Тархай бутархай байгаа бичил уурхайн байгууллага, үйл ажиллагааг нэгтгэж, их хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зорилгоор зуучлагчдыг ашиглах

Олон улсад алтны бичил уурхайн салбар нь төлөвшсөөр байна. Цаг хугацаа өнгөрөх тусам алтны бичил уурхайн үйл ажиллагаа нь эдийн засгийн үр ашигтай салбар болон хөгжих бөгөөд санхүү, хөрөнгө оруулалтын төрөл бүрийн багцуудыг санал болгох нь тодорхой юм. Хавсралт 1-д санхүү, хөрөнгө оруулалтын төрөл бүрийн эх үүсвэрүүд урт хугацаанд албан ёсны, мэргэшсэн алтны бичил уурхайн салбарыг хөгжүүлэхэд өөр өөр үүрэгтэй гэдгийг харуулсан.

6. Алтны бичил уурхай нь эдийн засгийн үр өгөөжтэй салбар болж хөгжих боломжтой

Донор байгууллагууд, буцалтгүй тусламж олгогч болон уул уурхайн компаниуд алтны бичил уурхайн салбарын хувьд зах зээлийн **дэд бүтцийг** нь бүрдүүлдэг. Тухайн дэд бүтэц бүрдүүлэгчдийн бий болгосон суурин дээр шинийг санаачлагчид орж ирснээр харьцангуй том хэмжээний үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Тэдгээр оролцогч талууд эрсдэл даах өндөр чадвартай бөгөөд “хүлээцтэй” гэж нэрлэгдэх хөрөнгө гаргах боломжтой байхаас гадна тэдний зүгээс зээлийн эргэн төлөлтийн хугацааг харьцангуй урт хугацаагаар хийж, сунгах боломжтой байдаг. Зарим тохиолдолд шинийг санаачлагчид зах зээлийн үнээс доогуур хэмжээтэй ашиг олохыг ч хүлээн зөвшөөрдөг байна. Энэ санхүүжилтийн эх үүсвэрийг албан ёсны алтны бичил уурхайн үйлдвэрлэлийг хариуцлагатай, санхүүжилт авах боломжтой гэдгийг харуулах зорилгоор ашиглаж болох бөгөөд мөнгөн усны хэрэглээг халах гэх мэт байгаль орчны болон нийгэм, засаглал, хөгжлийн зорилтуудыг хангах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой. Санхүүжилтийн талаарх сайн туршлага хуримтлуулж, түүнийгээ баримтжуулж салбарын хэмжээнд илүү сайн бүртгэл тооцоотой, баримттай болсон цагт бичил уурхайн салбарын хэмжээнд тулгардаг эрсдэлийг бууруулна. Энэ үед эрсдэлд илүү болгоомжтой ханддаг, хөрөнгө оруулалтаасаа баталгаатай ашиг олох зорилготой оролцогч талууд болох зах зээлийг тэлэгчид буюу санхүүжилтийн том сангууд, зах зээлийн жишгээр ашиг олох зорилготой нөлөөллийн хөрөнгө оруулагчид, арилжааны банкууд, том хэмжээний хувийн хөрөнгө оруулагч банкууд гэх мэт санхүүжүүлэгч байгууллагуудын анхаарлыг бичил уурхайн салбарт татах боломжтой юм. Ийнхүү сүүлийн шатанд хүрэхэд бичил уурхайн салбар өсөж төлөвшсөн байх бөгөөд албан ёсны санхүүжилтийг бүрэн хэмжээнд авах боломжтой болно. Энэ шинэчлэлийг бичил уурхайн салбарт бүхлээр нь нэвтрүүлэх шаардлагатай ч дээрх арга барилыг бичил уурхайн байгууллагууд зөвхөн өөрийн үйл ажиллагаандаа бие даан хэрэгжүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэд хэдэн хамтын ажиллагааг хөгжүүлснээр цааш өргөжин төлөвших боломжтой юм.

Зах зээл өсөж боловсрох тусам төрөл бүрийн санхүүгийн “хэлбэр”-үүд алтны бичил уурхайн салбарын түвшин бүрт ашиглагдаж эхэлнэ. **Шинийг санаачлагчид** эрсдэлийг илүү хүлээн авах чадвартайгаар алсыг харж бүтээлч хандана; **Шинэ салбарт эртнээс эхлэгчид** энэ бизнесийн гол хэсэгт давамгайлах зорилготойгоор боломжийн бөгөөд стратегийн ашиг, үр дүн эрж хайна; **Эртэч бүлэг** зардалд мэдрэмтгий, эрсдэлд болгоомжтой хандаж, баталгаатай санаа, энгийн тодорхой хамтын ажиллагаа эрж хайна; **Хожуу бүлэг** илүү хуучинсаг арга барилтай байхаас гадна эрсдэлд болгоомжтой хандан нийгмийн хариуцлагыг чухалчлан үзнэ; эцэст нь **хойш суугчид** хамгийн сүүлд оролцох бөгөөд магадгүй гадны ямар нэгэн нөлөөгөөр л энэ ажилд орох магадлалтай.²⁵ Дээр дурдсан судалгааны үр дүнд үндэслэн алтны бичил уурхайн салбарт шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдгээрийг оролцооны муруйгаар зураглаж Хавсралт 2-т харуулав.

Энэхүү зураглалаас харахад шинийг санаачлагчид болон эртэч бүлгийн худалдан авагчид, нөлөөллийн хөрөнгө оруулагчид (гэр бүлийн бизнес, нийгмийн хөгжлийн бонд, хөгжлийн санхүүжилтийн байгууллагатай хосолсон санхүүжилт болон дотоодын арилжааны банк гэх мэт), донор байгууллагууд болон буцалтгүй тусламжийн хөрөнгө, хариуцлагатай хөрөнгө оруулалт (хувиараа хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулагчдын холбоо) гэх мэт

25 Робинсон Л. (2009). Шинэ санаачилгын тархалтын хураангуй. Өөрчлөлтийг дэмжих нь. Дараах цахим хуудаснаас үзнэ үү: https://twut.nd.edu/PDF/Summary_Diffusion_Theory.pdf

санхүүжилтийн хэд хэдэн эх үүсвэр, алтны бичил уурхайн нөхөрлөлийн хөрөнгө оруулалт хэлбэрээр санхүүжилтийн олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг байна. Үндэсний банк гэх мэт байгууллагыг илүү уламжлалт буюу эрсдэлд болгоомжтой ханддаг санхүүжилтийн эх үүсвэр гэж үздэг боловч тэдэнтэй хийсэн зарим ярилцлагаас харахад хангалттай мэдээлэл, зөв дэмжлэгтэй байвал алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах боломжтой гэж үзжээ. Энэ нь алтны бичил уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг онилохдоо санхүүжилтийн хэлбэрээс илүү хөрөнгө оруулагчдын хэлбэрт илүү анхаарал хандуулбал илүү үр дүнтэй байна гэдгийг баталж байна.



7. Дүгнэлт

Алтны бичил уурхайчид болон тэдний хамт олны хувьд урт хугацаанд тогтвортой, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах алтны бичил уурхайн салбарыг хөгжүүлэхэд санхүү, хөрөнгө оруулалт болон зах зээлийн хүртээмжтэй байдал чухал юм. Алтны бичил уурхайн үйлдвэрлэл нь олон янз байдаг учир санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, үйл ажиллагааны механизм, түүний хөрвөх чадвар, бусад талуудын ашиглах боломжийн талаар ойлгож мэдэх шаардлагатай байдаг. Аливаа улсын засгийн газраас батлан даасан санхүүжилтийн багцууд болон нөлөөллийн хөрөнгө оруулалт гэх мэт хэд хэдэн санхүүжилтийн эх үүсвэр алтны бичил уурхайн үйлдвэрлэлд илүү тохиромжтой байдаг. Бодит болон олон нийтийн буруу хандлагаас үүссэн эрсдэлийг сааруулахад чиглэсэн санхүүгийн механизмыг бүрдүүлэх нь алтны бичил уурхайн үйлдвэрлэлд илүү өргөн хүрээний санхүүжилт татах гол түлхүүр болдог. Хөрөнгө оруулагчдын дунд нийтлэг байдаг алтны бичил уурхайн үйлдвэрлэлийг өндөр эрсдэлтэй салбар гэж үздэг хандлагаас шалтгаалж төрийн болон сайн үйлсийн сангийн хөрөнгийг хосолсон хөрөнгө оруулалт хэлбэрээр ашиглан хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад тулгарах эрсдэлийг сааруулах шаардлага байсаар байна. Түүнчлэн эрсдэлд тэсвэртэй, нөлөөлөлд суурилсан ашиг орлого ихтэй хүмүүс, нөлөөллийн хөрөнгө оруулагч гэр бүлийн бизнесийн бүлэг зэргээс хөрөнгө оруулалт, санхүүжилт эрж хайснаар алтны бичил уурхайн төслүүдэд хөрөнгө оруулалт авах боломж өсөх юм.

Цаашдаа, санхүүжилтийн талаарх сайн туршлага хуримтлуулж, түүнийгээ баримтжуулж салбарын хэмжээнд илүү сайн бүртгэл тооцоотой, баримттай болсон цагт эрсдэлд илүү болгоомжтой ханддаг хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах боломжтой бөгөөд хариуцлагатай алтны бичил уурхайн салбарын хөрөнгө оруулалтын цар хүрээ нэмэгдэх юм. Түүнчлэн, бичил уурхайчид болон хөрөнгө оруулагчдын аль алиных нь мэдлэг, чадавхыг бэхжүүлснээр албан ёсны санхүүжилтийн үйлчилгээг илүү ихээр авах боломж нээгдэнэ.

Санхүүжилтийн эх үүсвэр	Албан бус санхүүжилт	Донорын болон буцалтгүй тусламж	Зөвхөн нөлөөллийн санхүүжилт	Нөлөөлөл		Тогтвортой байдал	Хариуцлагатай үйл ажиллагаа	Зөвхөн санхүүжилт хийх
Алтны бичил уурхайн салбар дахь үүрэг	Зах зээлийн бүтэц бүрдүүлнэ			Зах зээлийн шинийг санаачлагчид				
				Зах зээлийг өргөжүүлэн тэлэгчид				
Үндсэн зорилго	Хангалттай ашиг орлого олох				Өрсөлдөхүйц хэмжээний санхүүгийн ашиг орлого олох			
				Байгаль орчин, нийгэм болон засаглалын эрсдэлийг сааруулах				
Хүсч байгаа ашиг, орлого				Байгаль орчин, нийгэм болон засаглалын талаар үргэлжлүүлэн ажиллах				
				Их хэмжээгээр нөлөө үзүүлэх, хэмжигдэхүйц шийдлийг танилцуулах				
Хөрөнгө оруулагчийн зорилго	Ашиг, орлого олох зорилгогүй		Хөрөнгө хамгаалах		Зах зээлийн жишгээс доогуур			
	Өрсөлдөхүйц				Өрсөлдөхүйц хэмжээний санхүүгийн ашиг орлого олох			
Хөрөнгө оруулагчийн зорилго	Байгаль орчин, нийгэм болон засаглалын талаар анхааралгүй зөвхөн ашиг орлого олох	Нийгэм, байгаль орчин, эдийн засгийн асуудалд анхаарч ашиг орлого олох талаар хүлээлтгүй	Нийгэм, байгаль орчин, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах ба хөрөнгө оруулагчид ямар нэгэн ашиг, орлого ирэхгүй боловч анхны хөрөнгө оруулалтыг хэвээр нь байлгах	Нийгэм, байгаль орчин, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхийн сацуу зах зээлийн боловч анхны доогуур хэмжээний ашиг, орлого олох	Нийгэм, байгаль орчин, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхийн сацуу өрсөлдөхүйц хэмжээний ашиг, орлого олох	Хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд байгаль орчин, нийгэм, засаглалын дэвшилтэт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалахын тулд байгаль орчин, засаглалын эрсдэлийг сааруулах	Зөвхөн ашиг орлого олох сонирхолтой бөгөөд байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал болон шаардлагыг хангах талаар маш хязгаарлагдмал байр суурьтай
	Баримт: *Орон нутгийн зээлдүүлэгчид *Мөнгөн усны худалдаачид *Алтны худалдаачид	Баримт: *Донорын болон буцалтгүй тусламж *Нийгмийн хариуцлагын хөтөлбөр (уул уурхайн компаниуд, алтны нийлүүлэлтийн сүлжээний дунд хэсэгт оролцогчид) *Олон улсын хөгжлийн	Хязгаартай баримт: *Гэр бүлийн бизнес *Нөлөөллийн хөрөнгө оруулагчид			Хязгаартай баримт: *Хувийн хөрөнгө оруулалт *Хувийн хөрөнгө оруулагчдын холбоо		Хязгаартай баримт: *Алтны бичил уурхайн төслүүдэд үндэсний банкнаас зээл олгох туршилт
Алтны бичил уурхайн салбарт ажилласан тухай баримт нотолгоо	Алтны бичил уурхайн санхүүжилтийн өнөөг хүртэлх үйл ажиллагаа							

Хавсралт 2. Алтны бичил уурхайн санхүүжилтийн асуудлыг хүлээн зөвшөөрөх муруй

Алтны бичил уурхайн санхүүжилт одоогийн байдлаар шинийг санаачлагчид болон эрт оролцогсдын ангилалд амрагдаж байна.

2.5% ШИННИЙГ САНААЧЛАГЧИД	13.5% ЭРТ ОРОЛЦОГСОД	34% ЭРТЭЧ БҮЛЭГ	34% ХОЖУУ БҮЛЭГ	16% АРД ХОЦРОГСОД
Ашигт малтмал худалдаалагчид (холимог хөрөнгө оруулалт, урсгалаар тохиролцох) бичил уурхайн бүлэгтэй эртнээс хамтарч ажилладаг.	Дотоодын арилжааны банк алтны бичил уурхайн салбарт батлан даагчийн хөтөлбөр гэх мэт гуравдагч этгээдийг оролцуулан хөрөнгө оруулах сонирхолтой.	Арилжааны банк алтны бичил уурхайн салбарт сонирхолтой байгаа боловч байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлыг баталгаажуулах гэрч баримт дутмагаас хязгаарлагдмал байдалтай байна.	Хувийн хөрөнгө оруулагчдын сан хэт их эрсдэлтэй хөрөнгө оруулах хэмжээний салбар биш гэж үздэг. Гуравдагч этгээдээр дамжуулан нөлөө гаргах хөрөнгө оруулалт хийж магадгүй л юм.	Баялагийн сан алтны бичил уурхайд хөрөнгө оруулах хүсэлгүй, боломжгүй байна. Учир нь энэ нь бизнесийн боломж гэж харагдахгүй байгаа бөгөөд байгууллагын бүтэц сул байгаа нь эрсдэл болж харагддаг. Эд хувьцаа эзэмшигчдийн үүргээр хязгаарлагддаг ба алтны бичил уурхайг хөгжилд хүндрэл учруулна гэж үздэг.
Хувийн хөрөнгө оруулагч (янз бүрийн нөлөөллийн сонирхолтой) орон нутгийн хамтрагчтай адил алтны бичил уурхайн байгууллагад хөрөнгө оруулсан.	Нийгмийн нөлөөллийн фонд алтны бичил уурхайн салбарт шинэ санаачлагын бүтээгдэхүүн нэвтрүүлэхийг дэмждэг.	Нөлөөллийн хөрөнгө оруулалт (ерөнхий) алтны бичил уурхай нь тэдний хувьд гол чиглэл биш юм.	Хувийн хөрөнгө оруулагчид 20 сая ам.долларын хөрөнгө оруулах зорилготой байгаа учраас одоогийн бүтцээр хөрөнгө оруулах боломжгүй гэдэг бөгөөд салбар бүхэлдээ эрсдэл ихтэй гэж үздэг. Гэсэн ч тогтвортой байдал илүү урт хугацааны сонирхолыг төрүүлж байна.	Баялагийн сан алтны бичил уурхайд хөрөнгө оруулах хүсэлгүй, боломжгүй байна. Гэд зөвхөн улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд бичил уурхай нь энэ чиглэлээс гадуур юм.
Нөлөөллийн хөрөнгө оруулалт нийгмийн төлөө ажилладаг байгууллагууд/ гэр бүлийн сан хамтран алтны бичил уурхайн төслүүдэд хөрөнгө оруулах талаар идэвхтэй ажилладаг.	Нөлөөллийн хөрөнгө оруулалт (холимог санхүүжилт) одоохондоо алтны бичил уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийгээгүй байгаа боловч сонирхож байгаа. Эрсдэлийг давах чадвартай.	Нөлөөллийн хөрөнгө оруулалт алтны бичил уурхайн салбарыг хөрөнгө оруулахад арай эрт бөгөөд үүнээс ямар ашиг олох нь тодорхой биш гэж үздэг боловч 2-3 жилийн дараа эргэж харна гэж боддог.	Уул уурхайн компани (ерөнхий) алтны бичил уурхайг эрсдэл гэж үздэг боловч нэг бүс нутагт зэрэгцэн оршиж ажиллахад боломжтой гэдгийг батлавал хөрөнгө оруулалт тэдний хоорондын зөрчлийг сааруулах шийдэл байж болох бөгөөд компаниуд үүнийг илүү сонирхож байна.	Баялагийн сан хувьцаа эзэмшигчдийн чиг үүргээс шалтгаалж алтны бичил уурхайд хөрөнгө оруулах боломжгүй боловч хэрвээ уул уурхайн компаниуд хөрөнгө оруулж эхэлвэл баялагийн сан дагах боломжтой.
Буцалтгүй тусламжийн сан (арилжааны зээлийг нээх зорилготой) алтны бичил уурхайн үйл ажиллагаанд идэвхтэй хөрөнгө оруулалт хийдэг.	Нөлөөллийн хөрөнгө оруулалт тусгай хөтөлбөрийн дагуу хөрөнгө оруулалт хийхийг сонирхож байгаа.	Нөлөөллийн хөрөнгө оруулалт алтны бичил уурхайн салбарыг хөрөнгө оруулалт татахад бэлэн биш гэж үздэг боловч яваандаа зах зээлийн жишигээр ашиг орлого олох, эрсдэлийг зохицуулах боломжтой гэж үздэг.	Нөлөөллийн хөрөнгө оруулагчид одоогийн байдлаар хөрөнгө оруулах боломжгүй гэж үздэг.	Нөлөөллийн хөрөнгө оруулагч ерөнхийдөө дэмжлэг үзүүлдэг салбар биш учраас алтны бичил уурхайд хөрөнгө оруулах тухай боддоггүй.
Бичил уурхай ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа (алтны биш) бизнесийн ашиг сонирхолтой хэрэгцээнд суурилсан санаачилга		Сангууд алтны бичил уурхайн төслүүдийг шалгаж үзсэн боловч энэ салбар арай бэлэн биш байна гэж дүгнэсэн.		Алт цэврэршүүлэх төв алтны бичил уурхай тэдний бизнесийн загварт багтдаггүй.
Орон нутгийн банк ба хөгжлийн сан алтны бичил уурхайн үйл ажиллагаанд зээл олгодог.		Нөлөөллийн хөрөнгө оруулалт алтны бичил уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхолтой боловч хэрэгцээ шаардлага нь хэт жижиг гэж үздэг (дөр хаяж >2 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаарддаг).		Хөрөнгө оруулалтын банк алтны бичил уурхайг сайн ойлгоогүйгээс зохимжгүй салбар гэж үздэг. Эдний хувьд эрсдэл багатай, баталгаатай ашиг олох зүйлд хөрөнгө оруулах сонирхолтой.
Алт цэврэршүүлэх төв нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, яваандаа энэ үйл ажиллагааны бизнесийн боломжийг харуулах зорилгоор алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулдаг.				Үндэсний банк одоогийн магадлан шинжилгээний шаардлагаас шалтгаалж алтны бичил уурхайн салбарт хөрөнгө оруулах боломжгүй.
Алт цэврэршүүлэх төв алтны бичил уурхайн салбарт нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулдаг.				Нөлөөллийн хөрөнгө оруулагч ямар ч төрлийн уул уурхайн төслийг санхүүжүүлэх төвлөлөгөөгүй.
Буцалтгүй тусламжийн сан алтны бичил уурхайн нийгмийн асуудалд анхаардаг.				
Хувийн хөрөнгө оруулагчдын консорциум алтны бичил уурхайн салбарт ашиг хуваалцах нөхцөлтэй ажилладаг.				
Нөлөөллийн хөрөнгө оруулагчид алтны бичил уурхайн төсөлд хөрөнгө оруулаад дуусахаар нь гардаг.				

Жич: Ярилцлагад оролцогсдоос авсан мэдээллийг алтны бичил уурхайг санхүүжүүлэх асуудлыг хэрхэн хүлээн авсан тухай муруйд тохирох хэсэгт нь тааруулан байрлуулсан болно. Үүнээс янз бүрийн санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн талаарх дүр зургийг харж болохоос гадна бичил уурхайн санхүүжилтийн талаарх муруйгийн хаана нь байхыг тодорхойлж байна. Эдгээр хариултын аль нь ч алтны бичил уурхайд хөрөнгө оруулах сонирхолгүй гэсэн үг биш юм.

Нийлүүлэлтийн сүлжээний төлөөлөлтэй хийсэн ярилцлагад үндэслэн алтны бичил уурхайн санхүүжилтийн асуудлыг хүлээн зөвшөөрөх муруйн тохирох хэсэгт байрлуулж зурагласан болно. (Хүлээн зөвшөөрөх муруйн онол, Рожерс, 2003)

БИЧИЛ УУРХАЙ ДАХЬ АЛБАН ЁСНЫ САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

Хавсралт 3 – Сэдэвчилсэн хураангуйн тухай

planetGOLD хөтөлбөрийн бэлтгэсэн энэхүү баримт бичигт алтны бичил уурхайн санхүүжилтийн үндсэн мөн чанар, энэ талаар дэлхий нийтийн хэмжээнд хуримтлуулсан туршлага, алтны бичил уурхайчдын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмж зэргийг багтаасан болно. Энэ баримт бичигт оруулсан зарим материал нь уг хөтөлбөрөөс гаргасан хоёр тайланд хэвлэгдсэн бөгөөд нэмэлт мэдээлэл, баримтаар баяжуулж тодруулах зорилгоор эмхэтгэн оруулав. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг доорх эх тайлангаас авах боломжтой.

► **Бичил уурхайн санхүүжилтийн боломж**, Эби Ифиа Хилсон ба Гэвин Хилсон, 2020 оны 5 сар;

► **Санхүүгийн хязгаарлагдмал боломжтой салбар-алтны бичил уурхайн санхүүжилтийг нээх нь**, Сара Кавен, Эшитон Картер ба Эд Боуи, 2020 оны 3 сар;

Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс хэрэгжүүлдэг planetGOLD хөтөлбөр нь 9 улсын Засгийн газар, хувийн хэвшил болон алтны бичил уурхайн салбартай хамтран бичил уурхайчдын үйл ажиллагаа, ажлын нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажилладаг. Энэхүү хөтөлбөр нь санхүүжилтийн хийдлийг нөхөх, албажуулалтыг дэмжих, мэдлэг түгээх, бичил уурхайчдыг мөнгөн усгүй технологи болон албан ёсны зах зээлтэй холбох чиглэлээр ажилласнаар илүү цэвэр, үр ашигтай, уурхайгаас зах зээл хүртэлх бүх оролцогч талуудад ашиг тустай алтны бичил уурхайн салбарыг хөгжүүлэх замыг тодорхойлохыг зорьж байна. planetGOLD хөтөлбөрийг НҮБ-ын Аж үйлдвэрлийн хөгжлийн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Олон улсын байгаль орчны байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

planetGOLD хөтөлбөрөөс эрхлэн гаргасан ‘Бичил уурхай дахь албан ёсны санхүүжилтийг нэмэгдүүлэх арга замууд’ сэдэвт гарын авлагыг planetGOLD Монгол төсөл монгол хэлэнд хөрвүүлэн нийтлэв. planetGOLD Монгол төслийг Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Канад Улсын Алтны бичил уурхайн зөвлөлөөс хамтран хэрэгжүүлдэг болно.

